

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Пүрэв гараг

| | | |
|----|--|---------|
| | <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | 1 |
| | <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | 2 - 6 |
| | <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 7 - 86 |
| 1. | <i>“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i> | 8 - 9 |
| 2. | <i>Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i> | 9 - 60 |
| 3. | <i>Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i> | 60 - 70 |
| 4. | <i>Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i> | 70 - 75 |
| 5. | <i>Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i> | 75 - 86 |

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 28-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн хуралдааны
товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 09 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, С.Амарсайхан, Ч.Анар, Т.Аубакир, Х.Баасанжаргал, Б.Батбаатар, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Б.Бейсен, Ш.Бямбасүрэн, С.Бямбацогт, Ж.Галбадрах, С.Ганбаатар, М.Ганхүлэг, Г.Дамдинням, Б.Жавхлан, С.Замира, М.Мандхай, П.Наранбаяр, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Б.Пүрэвдорж, Д.Рэгдэл, П.Сайнзориг, М.Сарнай, Р.Сэддорж, Б.Тулга, Ч.Ундрэм, Б.Уянга, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Ө.Шижир, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр, Д.Энхтуяа, С.Эрдэнэболд;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, Н.Номтойбаяр;

Тасалсан: Ж.Ганбаатар;

Хоцорсон: М.Бадамсүрэн – 19 минут, Э.Бат-Амгалан – 21 минут, Д.Батбаяр – 14 минут, Х.Баттулга – 38 минут, Х.Булгантуяа – 01 минут, Г.Ганбаатар – 53 минут, Б.Дэлгэрсайхан – 20 минут, Б.Жаргалан – 15 минут, Д.Жаргалсайхан – 1 цаг 24 минут, Б.Заяабал – 10 минут, С.Лүндэг – 12 минут, Л.Мөнхбаясгалан – 08 минут, П.Мөнхтулга 2 цаг 38 минут, З.Мэндсайхан – 13 минут, Ч.Номин – 04 минут, Ж.Чинбүрэн – 28 минут, Р.Эрдэнэбүрэн 26 минут.

**Нэг. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан танилцуулав.

Д.Амарбаясгалан: “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 18

Бүгд: 68

73.5 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Эх орончдын нэгдсэн намын дарга Г.Ганбат, Монголын Социал демократ намын Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Сандуйжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, С.Цэнгүүн, О.Цогтгэрэл, Л.Мөнхбаатар, Б.Найдалаа, Д.Бум-Очир, Ж.Баярмаа, А.Ундраа, Да.Цогтбаатар, Б.Түвшин, Ж.Алдаржавхлан, А.Ганбаатар, Д.Ганбат, Г.Ганбаатар, Д.Жаргалсайхан нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 11 цаг 20 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, А.Ундраа, Д.Ганбат нар үг хэлэв.

Уг асуудлыг 10 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, мөн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, Цөмийн энергийн комиссын ажлын албаны Тамгын газрын дарга Б.Баатарцогт, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын ахлах шинжээч Н.Од-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Г.Гэрэлмаа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Цэрэнчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, хуулийн төслийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, А.Ундраа нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Г.Гэрэлмаа, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн санал хураалтыг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Баасан гарагт явуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, мөн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, Цөмийн энергийн комиссын ажлын албаны Тамгын газрын дарга Б.Баатарцогт, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн

бодлогын газрын ахлах шинжээч Н.Од-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Г.Гэрэлмаа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Цэрэнчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, хуулийн төслийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, А.Ундраа нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Г.Гэрэлмаа, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийн санал хураалтыг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Баасан гарагт явуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, мөн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, Цөмийн энергийн комиссын ажлын албаны Тамгын газрын дарга Б.Баатарцогт, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын ахлах шинжээч Н.Од-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Г.Гэрэлмаа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Цэрэнчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх

С.Дунжидмаа, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, хуулийн төслийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Н.Наранбаатар, Д.Батлут нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийн санал хураалтыг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Баасан гарагт явуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 00 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 85 гишүүн ирж, 67.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ:

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 09 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Чуулганы хуралдааны ирц хүрсэн байна. Нийт 64 гишүүн ирцэд бүртгэгдэж, 50.8 хувьтай байна.

Өнөөдрийн нэгдсэн чуулган нээгдсэнийг мэдэгдье. /алх цохи/

11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар 5 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Гуравдугаарт, Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Тавдугаарт, Бага хэмжээний цөмийн материалыг шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-д “Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлгээс ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах” гэж заасны дагуу “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзоригийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболдыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагайг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2. Улсын Их Хурлын гишүүн Сонгобайн Замираг Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагайг Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболдыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзоригийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Улсын Их Хурал дахь намын бүлгүүд болон Улсын Их Хурлын гишүүдээс ирсэн өөрсдийн саналыг үндэслэн дараах энэ зохион байгуулалтыг хийж байгаа юм.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

73.5 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүддээ талархал дэвшүүлье.

Дараагийн асуудалд оръё.

Хоёр.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэлнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал танилцуулна.

Индэрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улс төрийн намын тухай хуулийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхлээд байна.

Тус хуульд зааснаар улс төрийн нам нь Үндсэн хуульт байгуулал, ардчилсан тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаагаа ардчилсан зарчимд нийцүүлэн шинэчилж, үндэсний хэмжээний бодлого дэвшүүлэн, ил тод, хариуцлагатай ажиллах чиг үүргийг хүлээх болсон.

Иймд Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намууд дотоод зохион байгуулалтаа хуульд нийцүүлэн шинэчилж, намын дүрэм, хөтөлбөрөө илүү өргөн хүрээгээр тодорхойлж, үндэсний хэмжээний бодлогыг дэвшүүлж, Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтөд оролцон ажиллах шаардлага үүсэж байна.

Энэхүү шаардлагыг харгалзан тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хойш 6 сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэсэн зохицуулалтыг хуульчилсан.

Гэвч хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2024 оны 6 дугаар сард Улсын Их Хурлын ээлжит сонгууль, 10 дугаар сард орон нутгийн сонгууль зохион байгуулагдаж, улс төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөр боловсруулах, нэр дэвшигчдээ тодруулах, сонгуулийн сурталчилгаа хийх, сонгуульд оролцох, сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хурал, шинэ Засгийн газрыг эмхлэн байгуулах зэргээр сонгуулийн үйл ажиллагаа явагдаж дуустал намын дүрэм журмыг шинэ хуульд нийцүүлэх боломж хомс байжээ.

Өнөөдрийн байдлаар Улсын дээд шүүхэд нийт 37 нам бүртгэлтэй байгаа бөгөөд тэдгээрээс 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд 22, орон нутгийн сонгуульд 12 нам, эвсэл тус тус оролцсон байна.

Намын дүрмээр гишүүдийн эрх, үүрэг, зохион байгуулалтын бүтцээс гадна намын удирдах дээд төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх болон хяналтын байгууллагыг байгуулах журам, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ болон намын салбар бүтцийн нэгжийг байгуулах, татан буулгах зэрэг асуудлыг цогц байдлаар зохицуулахаар хуульчилсан.

Түүнчлэн намын дүрэм, хөтөлбөрийг шинэчлэхэд гишүүдийн оролцоо, ил тод байдлыг хангах, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг баримтлах, мөн намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг намын удирдах дээд байгууллагын онцгой бүрэн эрхэд хамааруулан хуульчилжээ.

Өөрөөр хэлбэл намын дүрмийн гуравны нэгээс дээш хэмжээний өөрчлөлт оруулах асуудлыг намын анхан шатны бүх нэгжийг хуралдуулж, гишүүдийн оролцоог хангаж, шаталсан хэлбэрээр санал авсны үндсэн дээр намын удирдах дээд байгууллагаас эцэслэн шийдвэрлэж, улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр хуульд заасан.

Ийнхүү улс төрийн намын дүрмийн шинэчлэл нь гишүүдийн идэвх оролцоог хангахыг шаардсан өргөн хүрээний өөрчлөлтийг хамарч байгаа тул хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө санхүү, зохион байгуулалт, төлөвлөлтийг шаардсан төдийгүй тодорхой шат дамжлага бүхий бэлтгэл ажлыг хангахгүйгээр шууд хэрэгжүүлэх боломжгүй асуудал үүсээд байна.

Намын бүтэц, дүрмийг ардчиллын зарчимд нийцүүлэн шинэчлэхэд намын бүтцийн байгууллагуудад жөндөрийн тэгш байдал, хүйсийн төлөөллийн оролцоог хуульд заасан хэмжээнд бүрдүүлсэн байх шаардлага мөн тавигдаж байна.

Гэвч энэхүү шаардлагыг богино хугацаанд хангахад бэрхшээл үүсэж байна.

Ялангуяа Улсын Их Хуралд суудалгүй болон Улс төрийн намын тухай хуулийн 27.3-д заасан нөхцөлийг хангаагүй намуудын хувьд энэхүү шинэчлэлийг хуульд заасан хугацаанд хийж бүртгэлээ баталгаажуулах, жендэрийн тэгш байдлыг хангасан бүрэлдэхүүнээр хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулах боломж байдалд хязгаарлагдмал байна.

Улс төрийн намын дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг хуульд нийцүүлэн шинэчилж бүртгүүлэх нөхцөлийг хангах асуудлаар Монгол Улсын Засгийн газар болон Монгол Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн намуудад хандан Шинэ нам, Эх орончдын нэгдсэн нам, Зүй ёс нам, Бүгд Найрамдах нам, Үнэн ба зөв нам, Гэр хорооллийн хөгжлийн нам, Монголын социал демократ нам зэрэг улс төрийн намуудаас санал шаардлагыг ирүүлсэн.

Иймд улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах Үндсэн хуулийн суурь зарчим, жендэрийн тэгш байдал, гишүүдийн оролцоог хангах хуулийн шаардлагад нийцүүлж намууд өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг нэг мөр цогц байдлаар шинэчлэх боломжийг бүрдүүлэх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын хуульд заасан Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хугацааг түр хойшлуулах хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд танилцуулж байна.

Улс төрийн намын тухай хууль, түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа танилцуулна.

Индэрт урьж байна.

Э.Болормаа: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу намууд дүрмээ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн шинэчлэн баталж, Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр заасан хугацааг өөрчилж, улс төрийн намуудад дүрмээ шинэчлэх, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтаа боловсронгуй болгох бодит хугацааг тогтоож, хуулийн хэрэгжилтийг нэг мөр үр дүнтэйгээр зохион байгуулах шаардлагатай гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар улс төрийн намууд дүрмээ хуульд нийцүүлэн шинэчилж, Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр заасан хугацааг хойшлуулах бодит хэрэгцээ шаардлага намуудын байр суурь ямар байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар намын дүрмийг хуульд нийцүүлэн өөрчилж, Улсын дээд шүүхэд хүргүүлэх хугацааг өөрчлөх талаар намуудын гаргасан шаардлага, түүний агуулгын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагуудыг хангасан эсэх, хуульд заасан хугацааг хойшлуулснаар намууд дүрмээ өөрчилж бүртгүүлэх нөхцөл бүрдэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа одоогийн байдлаар хэдэн нам дүрмээ өөрчилж Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн талаар, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу хуулийн төслийг боловсруулсан эсэх, энэ өөрчлөлт нь Улс төрийн намын тухай хуульд заасан намын санхүүжилтийн талаарх зохицуулалтуудыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.10-д заасан зохицуулалттай нийцэж байгаа эсэх, хуулийн зарим зохицуулалтыг хойшлуулах бодит хэрэгцээ шаардлага бий эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хэлэлцүүлгийн шатад хуулийн төсөлд заасан хугацааг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор бүртгүүлэхээр өөрчлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Л.Мөнхбаатар нар нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг хуульд нийцүүлж шинэчлэн батлахад тодорхой хугацаа шаардлагатай байгаа тул хугацааг эргэн харах нь зүйтэй талаар, чуулганаар хэлэлцэх эсэхийг дэмжсэн тохиолдолд хуулийн төсөлд заасан хугацааг урагшлуулах боломжийг судлан үзэж хэлэлцүүлгийн үед өөрчлөх боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтэд анхаарч хугацаа алдахгүйгээр хуулийг хэрэгжүүлж улс төрийн намын шинэтгэлийг хийх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг хуульд нийцүүлж Улсын дээд шүүхэд бүртгүүлэх асуудлыг хуулийн төсөлд заасан хугацаанаас урагшлуулж, боломжит хугацаагаар тогтоох нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, О.Цогтгэрэл Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр заасан хугацааг хойшлуулахыг дэмжихгүй байгаа талаар саналаа илэрхийлсэн болно.

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 83.3 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Э.Болормаа гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын 11 дүгээр сарын 28-ны өдрийн чуулганы хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор ажлын хэсгийн гишүүд ирсэн байна. Танилцуулъя.

Баярсайханы Солонго Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Аюургиянын Золжаргал Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлогын газрын мэргэжилтэн, Ганчилын Ганбат Эх орончдын нэгдсэн намын дарга, Жамбын Сандуйжав Монголын социал демократ намын Ерөнхий нарийн бичгийн дарга, Батхуягийн Батсүх Гэр хорооллын хөгжлийн намын дарга, Базарсадын Жаргалсайхан Бүгд Найрамдах намын дарга, Лхамсүрэнгийн Энхтуяа Шинэ намын Хэрэг эрхлэх газрын дарга гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг иржээ.

Би бас Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан дээр Байнгын хороодод хуулийн төслүүд хуваарилсан талын мэдээллийг бас энэ дундуур хийе.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан байгаа.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газар 2024 оны 11 сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороонд.

2.Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2024 оны 11 сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд.

3.Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2024 оны 11 сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд.

4.Бага хэмжээний цөмийн материалыг шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2024 оны 11 сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна. /алх цохив/

Энэ төслийн хэлэлцэх эсэх асуудлыг даргын дэргэдэх зөвлөл дээр ярилцаад 150 минутаар хэлэлцэхээр болсон.

Нийт 28 гишүүн асуулт асууж, 4 гишүүн үг хэлэхээр буюу 32 гишүүн асуулт асууж, үг хэлэхээр байгаа.

Ингээд ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууя. Үг хэлэх дээр Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүний нэр байна.

Асуулт асуух үг хэлэх хоёр тусдаа нэр авч байгаа.

Ингээд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос нэг асуулт байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.4, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөл энэ хуулийн 36 дугаар зүйл Хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдүүлбэр хангасан эсэхийг хянах, энэ хуулийн 13.1.14-д заасан тохиолдолд хууль зүйн дүгнэлт гаргах, төслийг зохих журмын дагуу өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангах гэж.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлээр хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх журмын талаар зохицуулсан байх бөгөөд хуулийн 41.7-д Улсын Их Хурлын Тамгын газар энэ хуулийн 41.3-д заасны дагуу хянаж, эсхүл 41.5-д заасны дагуу хууль зүйн дүгнэлт гаргасан хууль тогтоомжийн төсөл хуульд заасан шаардлагыг хангаагүй гэж үзсэн бол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Улсын Их Хурлын даргад танилцуулж хууль тогтоомжийн төслийг энэ хуульд заасан шаардлага хангуулахаар хууль санаачлагчид буцаана гэсэн ийм заалт байна.

Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх гэж байгаа энэ асуудал Үндсэн хуулийн суурь зарчимтай нийцэж байгаа юу гэдэг энэ асуултыг нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт, 2024 оны 7 сарын 01-ний өдрөөс хойш 6 сарын дотор авч хэрэгжүүлэх, ялангуяа энэ Улс төрийн намын тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлтэй холбоо бүхий асуудал.

Энэ дээр тодорхой хугацааг хуульд зааж өгсөн. 2023 оны 7 сарын 07-ны өдөр батлагдсан Улс төрийн намын тухай хууль дагаж мөрдөх журмын тухай хууль анх өргөн баригдсан төслөөрөө батлагдсан.

Хуулийн хувийн хэргийг аваад үзэхээр хууль санаачлагчдаас өргөн мэдүүлсэн төслийн танилцуулахад дагаж мөрдөх хугацааны талаар огт дурдаагүй байгаа. Хугацааны талаар огт дурдаагүй байгаа.

Яагаад 6 сарын хугацаа гэсэн ямар судалгаан дээр үндэслэж энэ 6 сарын хугацаа гэдэг энэ хугацааг тогтоосон бэ гэдэг ийм судалгаа байгаа юу гэдгийг би бас асуумаар байна.

Гуравдугаарт, хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдүүлбэрт тавигдах шаардлага болон Улсын Их Хуралд хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх журмын шаардлагыг хэрхэн хангасан гэж үзэж байгаа вэ гэдгийг асуумаар байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хуулийн төсөл өргөн барьсантай холбоотой асуудлаар Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж дарга хариулъя.

Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон.

Б.Баасандорж: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Б.Баасандорж.

Хууль тогтоомжийн тухай хуулийн бүрдүүлбэр хянахтай холбоотой асуулаа.

Тэгэхээр Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад бүрдүүлбэр хянахаар ирүүлсэн.

Энэ төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэр гэсэн зүйлд заасан журмын дагуу Ерөнхий нарийн бичгийн дарга хянасан.

Яг Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэ хуулийн төслийн тухайд нийт бүрдүүлбэр дээр 10 зүйлийг шаарддаг. Хууль тогтоомжийн хуулиар.

Яг Улс төрийн намын тухай хуулийн өөрчлөлт нь яг 8 бүрдүүлбэрийн шаардлагад нь хангаж байгаа.

Өөрөөр хэлбэл яг Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан журмын дагуу бүрдүүлбэрийг хянаад, Улсын Их Хурлын дарга тов тогтоогоод Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн.

Тэгэхээр 40 дүгээр зүйлийн зөрчил байхгүй.

Д.Амарбаясгалан: О.Номинчимэг гишүүн асуулт асууна. Алга байна. Баярмагнайн Баярбаатар гишүүн. Б.Баярбаатар гишүүн асуулт асууна.

Б.Баярбаатар: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Улс төрийн намын хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд тодорхой зүйл, заалтад өөрчлөлт оруулахаар хэлэлцэж байна.

Тэгээд 2005 оноос хойш энэ улс төрийн намын хуулиа бид нэг шинэчилсэн найруулга оруулж ирж батлах гэж олон даваа нугачаа давж байж өнгөрсөн парламент Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснийг баталсан юм.

Тэгээд энэ хууль бол бас сайн хууль болсон гэж харж байгаа. Олон дэвшилтэт заалтуудыг оруулсан.

Дээр нь энэ намын дүрэмтэй холбоотой асуудал яригдаж байх шиг байна.

Тэгээд намын дүрэм бас тийм амар асуудал биш л дээ. Ер нь бол. Нэмэлт, өөрчлөлт оруулаад, хурлаараа хэлэлцүүлж батлуулахад бас намын гишүүдээр өргөн хэлэлцүүлэг өрнүүлдэг, анхан шатад хэлэлцүүлдэг гээд одоо улс төрийн намын дотоод амьдралыг энд яриулбал олон зүйл байгаа юм.

Тэгээд гаднаа энэ нэг тийм амархан юм шиг харагдаад байдаг. Яг улс төрийн намын дотоод зохион байгуулалт дээрээ орохоороо бас нэлээн зохион байгуулалтын ажил шаардагддаг ийм ажил байгаа юм.

Тэгээд одоо өнөөдөр ингээд 12 сар гарч байгаа. Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурал, орон нутгийн гээд ээлжит сонгуулиудыг явуулсан. Цаг хугацааны хувьд яагаад ч амжихааргүй болчихоод байгаа юм л даа. Аль ч улс төрийн намын хувьд.

Тэгээд дээр нь энэ Хууль тогтоомжийн тухай хууль зөрчсөн гээд нэг ийм мэдээлэл сүүлийн үед нэлээн яваад байна. Цахим орчинд. Би Н.Учрал сайдаас асууж байгаа шүү. Тийм.

Тэгээд яг энэ хууль тогтоомжийн хуулийн энэ 41.10 гэдгийг зөрчсөн юм уу, зөрчөөгүй юм уу? Үүнийг яг ойлгомжтой байдлаар энэ нийгэмд. Бид хууль зөрчсөнийг тогтоодог эрх бүхий субъект биш л дээ. Тэгэхдээ энэ бас нэг ийм ойлголтын зөрүүгээ арилгах нь зөв байх.

Нэг талдаа бид зөрччихсэн юм шиг яриад, нөгөө талдаа зөрчөөгүй юм шиг яриад. Тэгээд аль нь буруутай, аль нь буруугүй ч юм шиг ийм зүйл нэг буруу ойлголт яваад байгаа юм.

Тэгээд төсөл санаачлагчаас энэ асуултыг асууя.

Хэрвээ энэ зөрчөөгүй гэж үзэж байгаа бол яг ямар үндэслэлээр зөрчөөгүй үндэслэл байгаа юм бэ? Бусад шаардлагуудаа хангасан гэж үзэж байна.

Тэгээд энэ хугацааг хойшлуулахыг дэмжиж байгаа. Улс төрийн намууд энэ хуульдаа нийцүүлж дүрмээ нэлээн нухацтай шинэчилж батлах ёстой гэсэн ийм зарчмын байр суурьтай байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулъя.

Н.Учрал: Өнгөрсөн Засгийн газрын үед “5-Ш” ажиллагаа гээд явуулж байсан.

Тэгээд “шилэн ажиллагаа” гээд явуулахад Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 улс төрийн намаас 6 нам л санхүүжилтээ ил болгосон.

Тэгээд бусад намуудын санхүүжилт нь ил тод биш. Хурал зөвлөгөөнөө цаг хугацаанд нь хийдэггүй ийм олон улс төрийн намуудтай.

Тэгээд хааяа нэг идэвхэждэг.

Тэгээд үүнийг бид хуульчлаад энэ улс төрийн намын шинэчлэлийг хийхгүй нам өөрөө институт болж тогтохгүй учраас төр өөрөө бас бүрэлдэхэд өөрөө ийм хариуцлагагүй байдал хаана хаанаа байна гэж үзээд энэ Улс төрийн намын хуулийг тухайн үед Их Хурал дээр ажлын хэсэг байгуулаад энэ Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн хуулийг баталсан. Маш том дэвшил авчирч байгаа.

Тэгээд энэ хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлчихсэн.

Ингээд 01 сарын 01-нээс хойш 7 улс төрийн нам Улсын дээд шүүхэд шинээр бүртгүүлэх, нөгөө дүрмээ нийцүүлэх хүсэлтээ өгсөн юм байна.

Гэтэл дагаж мөрдөх журмын хуулийн дагуу буюу 2 дугаар зүйл дээр Улсын дээд шүүхэд үүрэг болгосон нэг заалт байгаа. Энэ үүрэг болгосон заалт юу юм бэ гэхээр 7 дугаар сараас хойш 6 сарын хугацаанд шат шатны хурлаа хийгээд, дүрмийнхээ саналыг аваад, энэ Улс төрийн намын хуулийн дагуу шаардлагуудаа биелүүлээд 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд шинэчилсэн дүрмээ бүртгүүлэх ийм дээд шүүхэд үүрэг болгосон заалт байдаг.

Тэгэхээр өнөөдөр энэ гишүүдийн дунд яригдаад байгаа одоо тэр хууль зөрчсөн эсэх дээр юу гэж тайлбарлах ёстой вэ гэхээр Улс төрийн намын хууль хүчин төгөлдөр мөрдөгдөөд эхэлчихсэн.

Хуулийн үйлчлэх хугацаан дээр ямар нэгэн өөрчлөлт оруулж байгаа зүйл огт байхгүй. Зөвхөн Улс төрийн намын хуулийг дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйл Улсын дээд шүүх 6 сарын дотор тэр нөгөө дүрмээ нийцүүлээд хурал зөвлөгөөнөө хийгээд дээд шүүх 30 хоногийн дотор бүртгэх гэдэг заалтыг тодорхой хугацаагаар хойшлуулбал нөгөө дүрмээ Улс төрийн намын шинэ хуультай нь нийцүүлээд батлуулах энэ боломжуудыг нь парламентад суудалгүй намуудад олгохгүй бол дахиад л энэ парламентад суудалгүй намууд чинь нөгөө шинэ хуулийн дагуу тавигдах шаардлагуудыг биелүүлэхгүй.

Тэгээд л нөгөө санхүүжилт нь ил биш. Хурал зөвлөгөөнөө хийхгүй. Нөгөө 40 хувийн жендерээ барихгүй ингээд яваад байх ийм эрсдэлтэй.

Хэрвээ энэ хугацаанд дүрмээ шинэчлэн боловсруулаад шат шатны байгууллагаараа дэмжүүлээд дээд шүүхэд хүргүүлэхгүй бол тухайн улс төрийн намыг дээд шүүх бүртгэхгүй гэдэг Улсын дээд шүүхийн тайлбар байгаа.

Тийм учраас хуулийн үйлчлэх хугацаа огт хойшлоогүй. Зөвхөн Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хугацааг үргэлжлүүлэх сунгах асуудал яригдаж байгаа юм. Түүнээс хуулийн үйлчлэх хугацаа энд хамаагүй. 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлээд хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа.

Д.Амарбаясгалан: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууна.

С.Цэнгүүн: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе.

Тэгэхээр намын дүрмийн талаар бид маш их яриад байгаа ч гэсэн намын хөтөлбөр гэж маш чухал бодлогын баримт бичиг байгаа. Тэр талаар огт хэн ч дуугарахгүй байгаад би их сэтгэл зовниж байна.

Тэгэхээр намын хөтөлбөр гэдэг маань энэ шинэчилсэн найруулга дээр бичихдээ намын үзэл баримтлал, үнэт зүйл, зарчимд тулгуурлан үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилго, бодлогыг тодорхойлсон үндсэн баримт бичиг байна гэж гаргасан байгаа юм.

Бид намын дүрмээрээ процессоо яаж гаргах юм, хэн яаж сонгогддог байх юм, үйл ажиллагаагаа явуулж, тодорхойлж байгаа бол намын хөтөлбөр гэдэг бодлогын баримт бичгээрээ намын үндсэн суурь маань, үнэт зүйлүүд маань байх юм. Гол бид нарын амин луужин болсон тэр цэг маань байх юм.

Тэгэхээр тэрийгээ бид огт ярилцахгүй байгаа юм байж зүгээр л хэн дарга байх юм, яаж сонгогддог байх процессыг агуулсан намын дүрэм дээрээ фокуслаад байгаад харамсалтай санагдаж байна л даа.

Тэгээд энэнээс болоод ямар асуудлууд үүсэж байна гэхээр нэг намд байгаа хүмүүс байж нэгэнт тэнд зах зээлийг чөлөөлнө, төрийн оролцоог багасгана гээд явж байхад яг нэг намаас сонгогдсон хүмүүс байж нөгөө талдаа банкны хүүг бууруулна, цалин нэм ч гэдэг юм уу ийм шаардлагууд тавиад байгаа чинь өөр утга учиргүй, нам дотроо хагарлуудыг үүсгэдэг үндсэн шалтгаан нь энэ байгаа юм.

Тэгээд хараад үзэхээр нэг юм нь одоо үнэхээр бид Улсын дээд шүүхэд материалаа бүрдүүлээд өглөө гэж бодоход тэр намын хөтөлбөр дээр байгаа бодлогууд дээрээ үнэхээрийн нэгдэж чадсан юм уу гэдэг асуудал. Хэрвээ материал буцаагдсан тохиолдолд яах вэ гэдгийг асуумаар байна.

Нөгөө талдаа бид ер нь энэ намын хөтөлбөр гэдэг зүйлст маш ач холбогдол өгч намын гишүүн болгон оролцоотой байх ёстой юм. Түүн дээрээ бид анхаарлаа илүү их хандуулах ёстой гэж бодож байна.

Тэгээд бас нэг зүйл байгаа нь ер нь энэ үзэл баримтлалаа дагадаг баймаар байгаа юм. Үзэл баримтлалаа намууд ч дагахгүйгээс болоод. Одоо жишээ нь, над руу энэ 12 сар болоод сая 100 жил болоод өнгөрсөн чинь баахан одон медалиуд

асуугаад байна шүү дээ. Манай намын гишүүд хүртэл над руу залгаад энэ одон медаль яаж авах вэ, одон медаль хөөцөлдөөд өгч болох уу гэдэг юм ярьж байгаа байхгүй юу.

Манай намын үзэл баримтлалаар энэ социализмын үеэс ирсэн энэ одон медалиуд дээр ямар бодлоготой байх юм гэдгээ хүртэл бид тодорхойлоод харуулах ёстой.

Тэгээд ер нь ардчилсан нийгэмд ирсэн бүтээмжээ үнэлүүлээд явдаг шинэ нийгэмд амьдарч байгаа хүмүүс байж социализмын үеийн одон медалиудаа больчихъё л доо.

12 саржингаа баахан одон медаль тарааж явна. Засгийн газар, яамдууд нь нэг жуух бичиг, ийм тийм гээд ингээд худлаа хуурамч хэнд ч үнэ цэнгүй болчихсон медалиудыг олон тоогоор нь тавьж өгдөг. Тэрийг нь олж өгсөн Улсын Их Хурлын гишүүнийгээ сайн хүн гэж ойлгодог. Үүнийгээ бид больмоор байгаа юм.

Тэгээд тэрийг болих үндсэн гол бодлогын баримт бичиг маань энэ намын хөтөлбөр гэж хараад байгаа.

Түүн дээр анхаарч тэр зүйлүүд рүү намуудыг шахаасай гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулъя.

Н.Учрал: Улс төрийн намын хуулийг дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйлийг Улсын дээд шүүхэд бүртгүүлэхтэй холбоотой Улсын дээд шүүхэд үүрэг болгосон заалтыг хугацааг нь нэг тодорхой хугацаанд сунгаж өгөөчээ л гэдэг ийм парламентад суудалгүй улс төрийн намуудын шаардлага л даа.

Тэгээд 37 улс төрийн нам байна. Эвлэлдэн нэгдэх Үндсэн хуулийн суурь зарчмыг бас хүндэтгэх ёстой гэдгийг бид ойлгож байгаа.

Тийм учраас Засгийн газарт парламентад суудалтай улс төрийн намуудын дарга нарт ийм шаардлага хүргүүлсэн. Энэ парламентад суудалгүй намууд.

Гэхдээ би нэг зүйлийг улс төрийн намуудын дарга нартай уулзахад ажлын хэсэг дээр хэлсэн.

37 улс төрийн нам хариуцлагатай байх ёстой. Улс төрийн намын шинэ хуулиар намын бүтэц, зохион байгуулалт, сая гишүүний ярьж байгаа тэр намын хөтөлбөр. Тэр хөтөлбөр нь бүх шатын байгууллагуудаараа хэлэлцүүлээд батлагдах ёстой.

Дээрээс нь шат шатны байгууллагууд нь тэр 40 хувь нь жендэрийг барих ёстой. Улс төрийн намын хуулиа хэрэгжүүлэх ёстой. Энэ бол хууль. 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн дагаж мөрдөөд эхэлчихсэн. Дүрмээ бүх гишүүдээрээ хэлэлцүүлэх ёстой.

Тэгээд гишүүдийнхээ тоог тодорхой болгох ёстой. “Жинхэнэ гишүүн” гэж байгаа бол дахиад “дэмжигч гишүүдтэй байж болно” гэдэг энэ Улс төрийн намын хуулиа хэрэгжүүлэх ёстой.

Ер нь улс төрийн намууд хариуцлагатай байх ёстой шүү дээ.

Гэтэл парламентад суудалгүй намууд юу гээд байна вэ гэхээр хоёр сонгууль болчихсон. Одоо бид нэг сарын дотор дүрмээ бүх гишүүдээрээ хэлэлцүүлээд 40 хувийг нь жендэрийг бариад ингээд явна гэхээр бид нарт хугацаа байхгүй байна. Тодорхой хугацаанд сунгаж өгөөч ээ гээд.

Ингээд Их Хурлын ажлын хэсэг энэ дээд шүүхэд бүртгүүлэх хугацааг тодорхой хугацаанд сунгаад өгөх шийдвэр гаргаад энэ хууль батлагдвал харин энэ хуулийг энэ хугацаандаа хэрвээ Улс төрийн намын хуулийн шаардлагуудыг парламентад суудалтай ч бай, суудалгүй ч бай намууд барихгүй бол хууль хэрэгжүүлэхгүй байвал Улсын дээд шүүх бүртгэхгүй гэдгээ Улсын дээд шүүх тайлбараар илгээсэн.

Тэгээд хаана хаанаа хариуцлагатай байя. Харин дээд шүүхэд бүртгүүлэх хугацаагаа энэ удаа тодорхой хугацаагаар сунгаад шинэ хуулийнхаа шаардлагуудыг та нар биелүүл. Харин түүнээс цааш барихгүй бол Улсын дээд шүүх бүртгэхгүй гэдэг тодорхой байр сууриа илэрхийлсэн байна лээ.

Тэгээд түүнээс цааш ер нь энэ олон намууд цэгцрэх, тэгээд нэгдэх нийлэх, тэгээд хаана хаанаа институт болох зөв соёл руугаа явах ёстой.

Тэгээд таны хэлж байгаагаар яг энэ хөтөлбөр дээр ажилладаг нам дэргэдээ нэг ийм бодлогын судалгааны хүрээлэнтэй байдаг, хөтөлбөрөө ярьдаг, бодлогын мэтгэлцээн хийдэг, улс төрийн намынхаа шинэчлэлийг бүгдээрээ үргэлжлүүлэх ёстой.

Энэ удаа тодорхой хугацаагаар бүртгүүлэх хугацаан дээр нэг үргэлжлүүлэх, сунгах асуудал ярьж байгаа болохоос биш үүнээс хойш дахиж парламент энэ асуудлыг ярихгүй. Улс төрийн намуудаа шаардаад шахаад явах ёстой. Улс төрийн намууд өөрсдөө хариуцлагатай байх ёстой л гэдэг ийм тайлбарыг хиймээр байна.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах хүн байгаа билүү.

Ер нь Улс төрийн намын тухай хууль 18 жилийн туршид нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга орж чадаагүй байж байгаад өнгөрсөн жил Монгол Улсын

Ерөнхийлөгч парламентад суудалтай, суудалгүй улс төрийн намуудын удирдах түвшинд зөвшилцлийг удаа дараа зохион байгуулж, онол практикийн хурлуудыг хийж, нам намын төлөөлөл орж ажилласны үндсэн дээр хууль шинэчилсэн найруулга хийгдсэн.

Маш их дэвшилтэт хууль болсон гэж үздэг.

Нэгдүгээрт олон улсын байгууллагууд, ялангуяа энэ улс төрийн намуудад тавигдах шаардлага, улс төрийн намаар дамжсан авлига, хүнд суртал, их олон зүйлүүдийг арилгах, манай Монгол Улсын тодорхой олон улсад эзлэх байр суурийг хүртэл тодорхойлох чиглэл дээр ахиц дэвшил гаргахад суурь шалтгаануудыг арилгах зорилготойгоор батлагдсан.

Нам гэдэг өөрөө институт байх ёстой. Тэр институтуудээс өрсөлдөөн дундаас парламент бүрдэж, илүү өндөр хариуцлагатай ажилладаг байх ёстой гэдэг үндсэн зорилго дээр энэ хуулийн шинэчилсэн найруулга хийгдсэн байгаа юм.

Манайд бүртгэлтэй 35 нам байдгаас өнөөдөр парламентад суудалтай нь 4 нам, эвсэл бүрдүүлсэн 2 нам буюу нийт 6 намын оролцоотой парламент бүрдчихээд байгаа юм.

Тэгээд бусад намууд одоо яг энэ түвшинд хүрэхийн тулд өөрөө хурлаа зохион байгуулж чаддаг байх, дүрмээ шинэчилж баталж чаддаг байх. Одоо нөгөө анх нам байгуулахдаа 801 хүний гарын үсэг зурж байгуулчхаад эргээд дүрмийн өөрчлөлт оруулах нөхцөл ирэхээр яг өнөөдрийнх шиг ийм хүндэрсэн нөхцөл байдалд ороод суучихдаггүй байх чиглэл дээр манай парламентад суудалтай, суудалгүй намууд энэ дээрээ их сайн анхаарч ажиллах ёстой байгаа юм.

Намууд хөгжихгүйгээр цаашаа явах боломжгүй гэдэг дээр их сайн.

Үүнийг хэрэгжих хугацааг нь хоёр дахь удаагаа хойшлуулах асуудал ярьж байгаа. Зүгээр нэг талдаа шүүмжлэлтэй хандаж байгаа гишүүдтэй санал нэг байгаа юм.

Хууль нэгэнт батлагдчихаад хэрэгжих гээд ирэхээр улс төрийн намуудад хүндэрсэн учир шалтгааныг яриад бас ийм асуудал хөндөгдөж байгаа нь намуудын хариуцлагатай байхыг илүү шаардаж байна л гэсэн үг.

Мэдээж парламентад суудалтай байгаа намууд нь бусад нь хамаагүй гээд хаяад явахад хүндрэл үүсэж байгааг талаасаа харгалзан үзэж байгаа юм.

Тэгэхээр энэ бүгд дээр аль аль талдаа хариуцлагатай хандах ёстой шүү гэдгийг хэлье.

Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Нэг жил хагасын өмнө батлагдсан энэ хууль одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа.

Тухайн үед энэ хууль батлагдаж байхад 2023 оны 7 сарын үед санагдаж байна. Би бас ажлын хэсэгт нь орж ажиллаж байсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн барьсан хууль маш чухал олон дэвшилттэй зүйл, заалтууд орсон ийм л хууль байсан. Намуудыг бодлогын чиглэлд нь хөтөлбө. Улсаас өгч байгаа, төсвөөс өгч байгаа, татвар төлөгчдийн мөнгөнөөс өгч байгаа санхүүжилтийг ил тод болгоё, нээлттэй болгоё. Тэр тусмаа үүнийг бодлогын судалгаанд нь, тэр тусмаа тэр нийгмийн эмзэг хэсгүүд рүү төрийн бодлого хэрхэн яаж чиглэх бодлогын судалгаанууд гээд хувь процентуудаар нь хүртэл заачихсан маш олон дэвшилттэй зүйл, заалтууд энэ хуульд бий.

Яг энэ хуулийн үзэл баримтлал, олон олон зүйл, нөгөө нэг нийгэмд болохгүй бүтэхгүй байгаа олон зүйлүүдийг бид харьцуулаад хэлдэг. Эх нь хээр алаг унаган шийр алаг гэдэг. Нийгмийн болохгүй бүтэхгүй байгаа олон зүйлийн үндэс шалтгаан улс төрийн намуудад байна. Дотоод ардчилалгүй, дотоод авлига бүхий л зүйлд байна гэж бид ярьж ярьчихаад хэрэгжилт дээр нь ирэхэд ийм байр суурь баримталж байгаа нь харамсалтай.

Тэр тусмаа яг энэ асуудал дээр Ардчилсан намын бүлэг дээр хуралдаад олонх гишүүд нь дэмжээгүй. Энэ асуудлыг.

Бас яагаад Ардчилсан намын бүлгийн гишүүд үүнийг дэмжээгүй вэ гэдэг гарч байсан байр сууриудаас би Та бүхэнд үүнийг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Зөвхөн Ардчилсан нам өөрөө парламентын нэг голлох улс төрийн хүчнүүдийн нэг.

Гэтэл Ардчилсан намын хувьд өөрөө институцийн хувьд сүүлийн 4 жил, сүүлийн 8 жилийн хувьд асар их дордчихсон. Дотоод зохион байгуулалт, хурлаа хийдэггүй, ярьдаггүй ийм л нөхцөл байдал бий болчихсон.

Одоо энэ нь энэ чигээрээ дахиад 4 жил шахуу 2028 он хүртэл үргэлжилнэ гэдэгт олон гишүүд санаа зовниж байгаа. Энэ өөрөө зөвхөн Ардчилсан намын өөрийнхөө асуудал бас биш ээ. Энэ өөрөө Монголын парламентын асуудал болж хувирна.

Энэ намууд нь чадвартай, чадавхтай, нийгмийн захиалгадаа нийцэж ажиллаж чаддаг байх энэ асуудал бол Монгол Улсын эрх ашиг, Монголын парламентын засаглалын эрх ашиг гэж бүгдээрээ энэ дээр санаа зовнидог.

Зөвхөн Ардчилсан намын хувьд гэхэд бид үзэл санааны нэг бүхэл бүтэн жигүүрийг эзэлж байх ёстой нам маань сая орон нутгийн сонгууль олон олон зүйлүүдээр бид нар Улаанбаатар хотын сонгогчдын, сэхээтэн давхаргын, бизнес эрхлэгчдийн, залуучуудын асар олон талын дэмжлэгийг авч чадаагүй. Шат шатны сонгуульдаа.

Энд Улсын Их Хурлын гишүүд, бүлгийн гишүүд бүгдээрээ санаад үүндээ бид зохион байгуулалтын болоод бусад зүйл дээрээ дүгнэлт хийе л дээ.

Гэтэл энэ зохион байгуулалтын асуудал олон олон сайн сайхан ярьсан зүйлүүд маань 2028 он хүртэл хойшлох нь гээд.

Тэгээд эндээс хамгийн гол нь эцэст нь бас ярих гэж байгаа зүйл надад асуулт алга.

Ер нь энэ хамтарсан засагт намууд бүгдээрээ очоод орчихсон. Намууд ялгаагүй болчихсон. Намууд ямар ч ялгаагүй болчихсон. Дахиад дээрээс нь энэ дотоод зохион байгуулалтын энэ олон дэвшилтэт болоод нийгмийн хэрэгцээ шаардлагын олон зүйлээ бид хийхгүй юм байна.

Тэгэхээр эцсийн дүндээ энэ чинь нэг ийм хариуцлагагүй хэдэн намуудын асуудал биш. Монголын парламентын чадвар, чадавхын асуудал, үнэлэмжийн асуудал, дархлааны асуудал. Үүний цаана Монгол төрийн үнэлэмжийн асуудал, олон олон зүйл бас болж хувирах вий гэдэг дээр санаа зовнисондоо. Хэдүүлээ хуулиа хэрэгжүүлэе л дээ. Бас энэ хуулиа бүрэн дүүрэн ашиглая л даа. Нийгмийн дэвшил хөгжлийнхөө төлөө ашиглая л даа гэдэг энэ байр суурь, санаа зовнил байгаа учраас Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх ёстой.

Хуулийн хойшлолтыг дэмжихгүй байх ёстой гэдэг бүлгийн байр суурь гарсныг Та бүгд дахин давтан дуулгая. Надад асуулт алга.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дарга Лхагвын Мөнхбаатар гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаатар: Улс төрийн намын тухай хууль 1990 оны 5 сарын 10-нд батлагдан гарсан.

Тухайн ардчилсан үйл явц, өнөөгийн нийгмийн тогтолцоог бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн ийм хууль л даа.

2005 онд тодорхой өөрчлөлтүүд орсон. 2019 оны Үндсэн хуулийн үзэл санааны дагуу 2023 онд томоохон өөрчлөлт ч хийгдэж шинэчлэн найруулагдсан.

Энэ бол нэлээн чухал хууль болсон. Энэ хууль хэрэгжээд явж байгаа юм. Энэ хуулийн хэрэгжиж байгаа хугацааг хойшлуулах тухай асуудал яригдаагүй.

Дагаж мөрдөх журмын тухай хуульд байгаа тодорхой хугацаануудыг өөрчлөх асуудал яригдаж байгаа.

Ер нь улс төрийн нам өөрөө төлөвшиж хөгжиж байж, институт болж байж л улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудал явах нь тодорхой.

Ер нь парламент ёсны суурь өөрөө улс төрийн намууд байгаа.

Тийм учраас улс төрийн намуудаа л хөгжүүлэх, бэхжүүлэх, төлөвшүүлэх энэ чиглэл рүү нь үйл ажиллагаа явуулах чиглэлээр л хуулиуд шинэчлэгдэн батлагдсан.

Зарим гишүүдийн ярьж байгаа шиг улс төрийн намаас сонгогдож гарч ирчхээд улс төрийн намыг байх шаардлагагүй, тараах нь зүйтэй гэсэн ийм ойлголтоор биш. Харин улс төрийн намуудаа бэхжүүлж бусад Улсын дээд шүүхэд бүртгэлтэй байгаа 37 намаа төлөвшүүлж, үндэсний хэмжээний нам болгох энэ чиглэл рүү нь бид явах ёстой гэж үзэж байгаа.

Шинэ өөрчлөлтийн дагуу намын үндсэн үйл ажиллагаа Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хууль тогтоомжид дүрмээр нийцүүлэх ийм улс төрийн шаардлага байгаа.

Энэ дотор намын дотоод зохион байгуулалтаа ардчилсан байх, ил тод байх, нээлттэй байх гэсэн энэ олон шаардлагуудыг хангасан өөрчлөлтүүдийг хийх ёстой.

Энэ өөрчлөлтүүдийг хийх зүйл маань одоогоор намууд хийгдээд явж байгаа байх.

Монгол Ардын намын хувьд энэ хуулийг хойшлуулах хэрэгцээ шаардлага байхгүй. Үүнийг хийх бүрэн боломжтой байгаа.

Гэхдээ бусад намуудаас тодорхой шаардлагууд ирсэн гэж байгаа. Би ажлын хэсгээс тодруулъя. Хэдэн намаас ямар шаардлагууд ирсэн юм? Энэ хугацаагаа хойшлуулах шаардлага байна гэж үзэж байгаа юм байна. Энэ талаар нь бас тодорхой мэдээлэл өгөөч ээ гэж хүсэж байна.

Хоёр дахь зүйл бол ийм байгаа юм. Энэ дагаж мөрдөх журмын тухай хуулиар хоёр зүйлийг тавьсан хугацаа байгаа юм. Энэ хоёр ямар хугацаа байна вэ гэхээр нэг нь 2025 оны 01 сарын 07-ноос өмнө дүрмээ шинэчилж бүртгүүлэх нэг асуудал байгаа юм.

Хоёр дахь асуудал нь, 2028 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө тавигдах нэг шаардлага байгаа. Энэ бол нам улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна гэж Үндсэн хуульд заачихсан энэ заалтын дагуу нийт сонгогчдын сонгуулийн эрх бүхий

иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэд эвлэлдэн нэгдэж байж нам байгуулах асуудал энд тавигдаж байгаа.

Энэ бол одоо өнөөдрийн статистикаар үзэх юм бол 22 мянган орчим иргэн нэгдэж байж нам болж, эвлэлдэн нэгдэж, цаашдаа үйл ажиллагаа явуулна. Нам бол институт болж хөгжих энэ суурийг тавьсан чухал заалт байгаа юм.

Тийм учраас энэ заалтыг хэрэгжүүлэхэд шаардлагыг хангаж байгаа өнөөдөр хэдэн нам байна. Цаашид 2028 оны 01 сарын 01 гэсэн энэ хугацаанд намууд эдгээр шаардлагыг хангах боломж байна уу, үгүй юу гэдгийг ажлын хэсгээс тодруулж асууя гэж бодож байна. Ийм хоёр шаардлага байгаа.

Тийм учраас хуульд заагдсан хоёр хугацаа байгаа.

Монгол Ардын намын бүлгийн хувьд хойшлуулах асуудлын хэлэлцэх эсэхийг нь шийдээд явъя. Хэлэлцэхийг нь шийдсэний дараа ажлын хэсэг гаргаад хугацааг нь ярилцаж болох юм гэж үзэж байгаа юм.

2027 оны 8 сар гэдэг бол урт хугацаа байна гэдэг зүйлийг манай Улсын Их Хурлын гишүүд, улс төр, парламентад суудалтай намууд ярьж байгаа учраас хугацааг нь ажлын хэсэг дээрээ тодорхой ярилцаад явах боломж байна гэж үзэж байгаа гэдгээ хэлье гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Бадрахын Найдалаа гишүүн асуулт асууна.

Б.Найдалаа: Үг хэлэхэд нэр өгөх гэж байгаад андуураад асуулт руу орж ирчихлээ. Би асуулт биш үг хэлье.

Улс төрийн намын тухай хууль 20 жил дуншиж дуншиж байгаад арайхийж батлагдсан. Сүүлийн 30 жил Монгол Улсад явж байгаа улс төрийн салбарт маш том шинэчлэлийг авчирч байгаа хууль.

Олон дэвшилт зүйл орсон. ХҮН намын хувьд одоо яриад байгаа тэр дүрмийн өөрчлөлт байна уу, шинэ хуульд нийцэх асуудлаар ямар ч асуудал байхгүй. ХҮН намын хувьд ирэх долоо хоногт ч гэсэндээ Их Хурлаа хийгээд бүх асуудлыг нийцүүлээд дүрмээ батлаад бүртгүүлчхэж чадна.

Угаасаа ХҮН намын хувьд сүүлийн хоёр, гурван жил энэ хуулийн төсөл дээр манай багийнхан маш сайн ажилласан.

Дээр нь ХҮН намыг 10 жил хөгжүүлж байгаа, байгуулж байгаа, бэхжүүлж байгаа энэ бүх концепт, үзэл санаа нь одоогийн энэ улс төрийн намд шингэсэн байгаа.

Жишээлбэл, тэр дэмжигч гишүүн, жинхэнэ гишүүн угаасаа бид хийгээд ирж байсан. Бодлого, судалгааны хүрээлэн байна. Угаасаа бид хийгээд ирж байсан. Бэхэжсэн. Жендэрийн асуудал байна. Гэх мэтээр ХҮН намын хувьд асуудал байхгүй.

Зүгээр бусад намууд, парламентад суудалгүй намууд нэгэнт ийм хүсэлт тавиад Улсын дээд шүүхэд дүрмээ бүртгүүлж хугацааг нь хойшлуулах бодитой хэрэгцээ байгаа бол энд сууж байгаа Улсын Их Хурлын гишүүд, энд суудалтай намууд хүндэтгэн үзэх ёстой гэж бодож байна.

Яагаад гэвэл улс төрийн намын шинэчлэл, ер нь институцийн шинэчлэл хоёр, гурван жил хийчихдэг зүйл биш. 20 жил явж байгаа зүйл. Дахиад энэ хууль нь хэрэгжээд явж байгаа. Дүрмүүдээ бүртгүүлээд, дахиад бэхжээд, дүрэм нь зөвхөн цаас биш ажил дээр, амьдрал дээр хэрэгжээд үйлдэл болохын тулд, институц болохын тулд дахиад хоёр, гурав байтугай 5, 10 жил болно.

Тийм болохоор 20 жил явж байгаа том шинэчлэлийг хийж байж одоохон энэ ирэх сарын дотор өөрчлөөдөхье гэж яарч даарч болохгүй.

Тэгээд бусад намуудын тэр тавьж байгаа шаардлагыг бид бас ойлгож байна. Үнэхээр үүнийг хийхийн тулд зөвхөн нэг дүрэм хийгээд батлах нэг асуудал. Баталчихсан дүрэм дээрээ зодолдоод байдаг биз дээ.

Тэгээд энэ чинь цаанаа агуулгын хувьд дүрмээ сайн ярилцаагүй, судлаагүй, яаран таран хийснээс л болж байгаа шүү дээ.

Тийм болохоор энэ намуудын тавьж байгаа шаардлагыг зөв гэж бодож байна.

Харин энд сууж байгаа Улсын Их Хурлын гишүүд үгүйсгээд яаран дааран шахах биш харин ч бараг хэрвээ ямар нэгэн туршлага мэдлэг юу байгаа бол бусад намуудтайгаа хуваалцаад, зөвлөөд, заагаад ярилцаад хийх ёстой гэж бодож байна.

Тэгэхээр ямар ч байсан хэрэгжих хугацааг нь хойшлуулах биш хэрэгжээд явж байгаа хууль. Ганцхан тэр Улсын дээд шүүхэд бүртгүүлэх гэж байгаа тэр хугацааг нь хойшлуулж байгаа.

Өөрөөр хэлбэл дүрэмдээ тэр заасан бүх зүйлсийг шингээх. Зөвхөн үгийг нь биш үйлдлийг нь, ажлыг нь зохион байгуулах тэр хугацааг нь л олгож байгаа гэж ойлгож байгаа.

Тийм болохоор угаасаа 20-иод жил явж байгаа шинэчлэлийг үр бүтээлтэй болгохын тулд одоо ингэж яарч даарч болохгүй.

Тийм болохоор парламентад суудалгүй байгаа намуудын хүсэлтийг хүлээж аваад 2 жил хойшлуулахад бид 20 жилийн, 30 жилийн илүү үр дүнтэй улс төрийн тогтолцоог бүрдүүлэхэд маш чухал нөлөөтэй болно. Ийм газар яарч болохгүй.

Тийм болохоор үүнийг дэмжээд явах ёстой. Угаасаа Улс төрийн намын тухай энэ хууль хэрэгжээд явж байгаа гэдгийг онцолж хэлэхгүй бол хуулийг нь хойшлуулах гээд байна гэсэн андуурал яваад байна лээ.

Тэгээд ХҮН намын хувьд бид нарын хувьд асуудалгүй. Ганцхан бусад намуудаа хүндлээд хамтдаа энэ Монголын улс төрийн орчныг цэвэрлэхийн тулд, бэхжүүлэхийн тулд саяын энэ хуулийн төслийг дэмжих ёстой гэж үзэж байгаа. ХҮН нам дэмжинэ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууна.

Д.Бум-Очир: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Маш чухал хууль. Ач холбогдолтой олон чухал зүйл, заалтууд орсон гээд гишүүд зөндөө ярьчихлаа.

Миний асуумаар байсан зүйлийг түрүүн бас нэлээд олон гишүүд асуусан. Б.Бат-Эрдэнэ гишүүн хамгийн түрүүнд үг хэлж асуулаа. Тэр хойшлуулах хугацааны тухай асуудал.

Энэ хоёр дахиа хойшлуулах тухай асуудал болоод байна шүү дээ.

Энэ бол нөгөө талдаа улс төрийн намууд маань бас их хариуцлагагүй байгааг харуулж байгаа зүйл байхгүй юу. Эндээ намууд маань Их Хуралд суудалтай, суудалгүй бүхий л намууд маань хариуцлагатай хандмаар байна.

Энэ хуулиа хойшлуулах тухай асуудал дээр хууль биш ээ. Одоо тэр дагаж мөрдөх журам дээр янз бүрийн хугацаа яваад яригдаад байх юм. 2 жил гээд л, 6 сар гээд л. Тодорхой бус гээд ингээд гарч байна.

Сая Л.Мөнхбаатар гишүүний үгэн дээр, намын бүлгийн даргын үг дээр бас гарч байна. Ажлын хэсэг дээр тэр хойшлуулах хугацаа оруулж ирнэ гэж.

Тэгээд эндээс би бараг хариултаа авчих шиг боллоо гэж бодож байна.

Хойшлуулах хугацаа 2 жил байх шаардлагатай юм уу, үгүй юм уу. 2027 он хүртэл. Энэ арай урт юм биш үү. Улс төрийн намууд маань өөрсдөө хариуцлагатай хандаад. Мэдэхгүй. Хоёр, гурван сарын дотор ч юм уу, 6 сарын дотор ч юм уу их хол сунгахгүйгээр ойрхон сунгаад. Энэ хоёр дахиа хойшлуулах гэж байгаа тухай асуудал шүү дээ.

Жаахан хариуцлагатай хандаач ээ л гэж хэлмээр байна л даа.

Энэ улс төрийн намууд маань өөрсдөө хариуцлагатай хандахгүй байгаа учраас хойшлуулаад байгаа хэрэг шүү дээ.

Тэгэхээр энэ бол өөрсдөө ингэж намууд хариуцлагагүй байгаа байдлаа харуулаад илэрхийлээд баймааргүй. Энэ асуудалд хариуцлагатай хандчихмаар байна гэдгийг хэлэх гэсэн юм.

Тэгээд үндсэндээ ажлын хэсэг дээр хугацааг нь дахиж яриад оруулж ирэх юм байна гэж ойлголоо. Хэрвээ нэмэлт хариулт байвал энэ хугацаан дээр хариулт хэлж өгөхгүй юу. 6 сар, 2 жил, тодорхой бус хугацаа гэдэг ийм гурван үг би сонсоод байна.

Тэгэхээр зөв ойлгоод байна уу, үгүй юу. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Өнөөдөр уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудал шийдэгдэж байгаа.

Хэлэлцэх эсэх асуудал шийдэгдсэний үндсэн дээр харьяалах Байнгын хороонд шилжинэ. Албан ёсоор ажлын хэсэг байгуулагдана.

Тэгээд түрүүн Л.Мөнхбаатар даргын хэлсэнчлэн ажлын хэсэг дээрээ хугацаатай холбоотой, нөхцөл байдалтай холбоотой асуудлаар Улсын Их Хурлын гишүүд нарийн деталь ярих нь зүйтэй гэж бодож байгаа юм.

Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Тэгээд л нэг асуудаг. Тэгээд л хариулт нь нэг тийм гөлөг төөрүүлж байгаа юм шиг л юм болоод байна л даа.

Өчигдөр би асуусан. Тодорхой хариулт аваагүй. Хамгийн нэгдүгээрт хуулийн талаас нь асуумаар байна.

38 гээд Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.1, 38.7 дээр байна уу олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулах ёстой гэж байгаа.

Тэгээд тэр хэлэлцүүлгээс гарсан үр дүнг саналыг товьёг болгож бүрдүүлбэр хэсэгт хавсаргана гэж байгаа юм.

Тэгэхээр олон нийт маань юу гэж үзсэн юм бол оо? Олон нийт юу гэж үзсэн. Тэрийг нь хэрхэн хавсаргасан тухай бичээч. Энэ бол бүрдүүлбэр дутуу гэж би хараад байгаа юм.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос асуугаад байхгүй гэж хэлсэн.

Тэгэхээр энэ чинь нөгөө хууль тогтоомж зөрчигдөж байна.

Хоёрдугаарт, олон нийтийн санаа бодолд тусгагдаагүй байна. Ер нь улс төрийн нам гэдэг чинь хамгийн гол юм чинь олон нийтийн иргэдийн хүсэл сонирхлыг илэрхийлэгч байх ёстой шүү дээ. Улс төрийн хүсэл сонирхол.

Тэгэхээр улс төрийн хүсэл сонирхол нь юу юм бэ гэхээр чинь шударга, ёс, авлига, юу байдаг юм, энэ бүгдээс ангижруулаад өгөөч ээ. Биднийг сайхан ирээдүй рүү хөтлөөч ээ гэсэн ийм л санаа зорилготой байгаа шүү дээ.

Тэгээд тэрийг нь илэрхийлэх энэ намууд нь өөрснөө ийм хариуцлагагүй хандчихаад, тэгээд хариуцлагагүй байсныхаа төлөө сав л хийвэл хуульд өөрчлөлт оруулдаг нэг ийм юм руу л орох гээд байдаг болох гээд байна шүү дээ.

Гэтэл энэ чинь тийм байж болохгүй шүү дээ. Хуульдаа нийцүүлж амьдрах ёстой болохоос биш, өөрсдийнхөө зохион байгуулалтгүй асуудлын дагуу хуулиа өөрчилж байж болохгүй шүү дээ.

Тэгээд цаашаа ярих юм бол энэ чинь Ерөнхийлөгчийн санаачилж өргөн барьсан хууль байгаа. Өөрөө энэ мөрийн хөтөлбөрийнхөө 1.1.9 дээр маш тодорхой заачихсан байдаг. Улс төрийн намуудыг шинэчлэлийг нь гүнзгийрүүлмээр байна, ёс зүй сахилга хариуцлагыг нь дээшлүүлмээр байна, санхүүжилтийг нь шилэн болгомоор байна гээд. Энэ бүгд уялдаж байгаа.

Тэгээд үүнийг хойшлуулах юм бол Ерөнхийлөгч маань хориг тавьчих юм биш биз дээ.

Дахиад нэг асуулт юу вэ гэхээр энэ санхүүжилттэй холбоотой. Яагаад гэвэл Улс төрийн намын тухай хуулийн чинь 26 дугаар хэсэг бүхэлдээ санхүүжилтийн тухай байгаа.

Тэгээд ингэж байгаа юм. 26.3.3 дээр санхүүжилт бол намын хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд 15 хувийг нь зарцуулна гээд. Намын хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд гэж байгаа шүү дээ.

Тэгээд 26.6 дээр хэрвээ энэ заасны дагуу хэрэгжүүлэхгүй юм бол улсын төсөвт энэ өгсөн мөнгөө буцаан татна гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр ямар хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэж энэ 15 хувийг нь зарцуулах юм болоо? Яагаад гэвэл мөрийн хөтөлбөрөө, дүрмээ хэрэгжүүлэхгүй 2 жил хойшлуулъя гээд байна шүү дээ.

Тэр дараа жил авсан мөнгөнийхөө 15 хувийг нь энд зарцуул гээд энэ хуульд чинь заачихсан байхад энд нь зарцуулахгүй юм бол одоо тэгээд энэ хуулийн хэрэгжилт чинь хангагдахгүй гээд мөнгө нь буцаан татагдах юм биш үү.

Тэгээд улс төрийн намуудад их асуудал байдаг. Би бүр анх чуулганы нээлттэй шахам хэлж байсан. Одоо зарим. Бүх намыг хэлж байгаа юм биш. Зарим жижиг намууд ний нуугүй хэлэхэд туслан гүйцэтгэгчийн үүргээр оролцдог шүү дээ. Сонгуульд.

Сонгинохайрхан дүүрэгт явагдсан шүү дээ. Нэг том намын нэрийн дэвшигчтэй цуг нэг жижиг намын нэрийн дэвшигч мөнгө тараасан нь баригдсан шүү дээ. Баригдаад Сонгинохайрхан дүүрэг цагдаа, тагнуулд өгсөн.

Тэгээд тэр хэрэг юу болсныг би мэдэхгүй байна. Би үүнийг сонгуулийн чуулганы нээлт дээр хэлж байсан.

Тэгэхээр зохион байгуулалтгүй, хариуцлагагүй байсных нь төлөө бусад тэр хариуцлагатай байгаа 7 нам өгчихсөн байгаа шүү дээ.

Бүхэл бүтэн 7 нам энэ асуудлаа шийдээд дээд шүүхэд материалаа өгчихсөн байхад яагаад энэ олон жилийн түүхтэй, 30 гаруй жилийн түүхтэй манай Социал демократ нам, Бүгд найрамдах нам өгч чадахгүй гээд ингээд суугаад байгаа юм бэ?

Энэ хариуцлагагүй байдлаас болж сав л хийвэл хуульд өөрчлөлт оруулдаг энэ явдлыг дэмжмээргүй байна.

Улс төрийн нам ямар зорилготой вэ гэдгээ дахиж санах хэрэгтэй. Ард иргэдийн улс төрийн ашиг сонирхлыг илэрхийлэгч, улс төрийн хүсэл, тэр эрх ашигт нь нийцүүлж үйл ажиллагаагаа явуулна.

Гэтэл олон нийт юу гэж үзэж байгаа нь байхгүй, бүрдүүлбэр нь дутуу.

Тэгээд л нэг хэдэн нам хүсэлт гаргасан гээд л дайраад байгаа байхгүй юу. Бүхэл бүтэн 2 жилээр хойшлуулах гэж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Тийм. Энэ улс төрийн намууд үнэхээр хариуцлагагүй байна.

Улс төрийн намын хуулийн шинэчлэлийг хийх гээд энэ чинь орон даяар хэлэлцүүлгийг хэд хэд хийсэн. Тэгээд энэ Ерөнхийлөгч өргөн мэдүүлсэн хууль дээр чинь ажлын хэсэг гаргаад тухайн үед парламентад суудалтай намууд ч

оролцсон, суудалгүй намууд ч оролцсон. Нэлээд өргөн цар хүрээтэй хэлэлцсэн шүү дээ.

Тэгээд хамтдаа баталсан.

Тэгээд одоо болохоор парламентад суудалгүй намууд хугацаа давчуу байна.

Тэгээд наад шинэ дүрмээ бүртгүүлэх гэхээр, шинэ хөтөлбөрөө бүртгүүлэх гэхээр энэ дээд шүүхэд чиглэл болгочихсон дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйлийг тодорхой хугацаанд сунгаад өгчихвөл бид яг энэ хуулийнхаа дагуу дүрмээ шинэчилчихье.

Ялангуяа бүх шатынхаа намын гишүүдээс саналыг нь сонсох хуулийн шаардлага их өндөрдөөд байна. 2024 он чинь парламентын сонгууль, орон нутгийн сонгууль болчихлоо гээд шаардлага тавиад байгаа юм л даа.

Хэрвээ бид шууд Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хугацааг сунгахгүйгээр явбал одоо энэ нэг сарын хугацаа, тэгээд он гараад нэг сарын дотор Улсын дээд шүүхэд шинэ дүрмийн дагуу намууд бүртгүүлээд эхэлбэл ер нь бараг 25-аас 30 нам нь Улсын дээд шүүх бүртгэхгүй байх нөхцөл байдал үүсэх юм билээ.

Яагаад гэхээр Улсын дээд шүүх тийм тайлбар ирүүлсэн. Хэрвээ дүрэмд нийцүүлэхгүй бол, энэ шинэ хуулийн шаардлагаа биелүүлэхгүй бол бүтэхгүй шүү гээд.

Тэгээд мэдээж бас Үндсэн хуулийн энэ эвлэлдэн нэгдэх суурь зарчим байна.

Тэгээд таны хэлж байгаагаар олон нийтийн гэхээсээ илүү энэ эрх ашиг нь хөндөгдөөд байгаа буюу өөрсдийнх нь асуудлыг, өөрсдийнх нь харилцааг зохицуулах гээд байгаа улс төрийн намын хуулийн оролцогч нар буюу энэ 37 улс төрийн намууд чинь өөрсдөө бид нэг тодорхой хугацаа сунгачихвал яг энэ шинэ хуулийнхаа дагуу бүх асуудлаа нийцүүлээд явчихъя гээд байхаар бид бас сонсохгүй байж болохгүй байгаа юм л даа.

Тийм учраас Улс төрийн намын хууль хугацаа хойшилж байгаа ойлголт огт биш. 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжээд эхэлчихсэн. Жишээ нь, би бусад намыг мэдэхгүй байна л даа.

Жишээ нь, Монгол Ардын нам бол энэ Улс төрийн намын хууль батлагдсанаас хойш. Өмнө нь ч гэсэн дэргэдээ тэр бодлогын хүрээлэнгээ байгуулаад л, энэ хөтөлбөрөө хэлэлцүүлээд л, шат шатны намын гишүүдээсээ дүрмийн саналыг нь аваад л, санхүүжилтээ ил болгоод л ингээд л явж байгаа.

Бүх намынхаа гишүүдийг цахимаар бүртгээд л, нэг аппликэйшн дээр гишүүддээ мэдээллийг хангаад л ингээд явж байгаа.

Гэтэл бусад институцүүдийн хувьд бас бэлэн байна уу, үгүй юу. Бид сонсох л ёстой шүү дээ.

Түүнээс шууд хэрэгжүүлээд л явъя гэвэл, тэр Улсын дээд шүүхдээ хугацаандаа бүртгүүлье гээд явъя гэвэл энэ парламентад суудалгүй намууд чинь одоо тэгээд бүгд дээд шүүх бүртгэхгүй байдал үүсвэл бид яах вэ.

Энэ Их Хурлын танхимд байгаа намууд л нам. Бусад нь байж болохгүй гээд сууж байх уу гээд бас асуух л ёстой.

Тийм учраас улс төрийн намуудын дарга нар бас өөрсдөө хариулах хэрэгтэй.

Та нар хугацаандаа хуулийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Б.Солонго дарга хариулах уу? Энэ удаа бэлэн байна уу, үгүй юу. Эсвэл дараагийн хүний асуултад хариулчхаач.

Одоо хэрэгжиж байгаа Улс төрийн намын тухай хуулиар улс төрийн намуудын хурал зөвлөгөөнөө зохион байгуулах зохицуулалт бүрэн баталгаатай, нээлттэй байгаа. Тийм ээ.

Тэрийг одоо хариулахад бэлэн байна уу? Н.Жамъянхүү дарга. Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын газрын дарга.

Н.Жамъянхүү: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хууль зүй, дотоод хэргийн яам. Н.Жамъянхүү.

Түрүүн Ж.Баярмаа гишүүний асуултад бас нэмээд хариулчихъя.

Хууль тогтоомжийн хуулиараа олон нийтийн хэлэлцүүлэг олон нийтээс санал авах талаар нарийн заагаад өгчихсөн байгаа. Ялангуяа 38 дугаар зүйлын 6 дахь хэсэг болон 6, 7 дахь хэсгүүдэд.

Энд юу гэж заасан бэ гэхээр хэд хэдэн хэлбэрээр олон нийтийн хэлэлцүүлэг хийх буюу олон нийтээс санал авахаар заасан байгаа.

Тухайлбал, бичгээр санал авах байгаа. Уулзалт хэлэлцүүлэг болон олон нийтийн хэлэлцүүлгийг биечлэн зохион байгуулах, санал асуулга явуулах, цахим хэлбэрээр авах болон бусад хэлбэрээр гэсэн байна.

Тэгэхээр Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг цахим хэлбэрээр саналыг иргэдээс авсан байгаа. Тодорхой хугацаа.

Хууль тогтоомжийн хууль дээр тодорхой хугацаа зааж өгсөн байдаг. Ялангуяа 15 хоногоос доошгүй хугацаагаар авах ёстой гээд. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 11 сарын 05-ны өдрөөс цахимаар санал авах ажлыг эхлүүлсэн.

Ингээд тодорхой саналууд тухайн хугацаанд ирээгүй. Харин Улсын дээд шүүх болон бусад намуудаас тодорхой саналууд ирсэн.

Мөн энэ ажлын хүрээнд Засгийн газрын гишүүд болон холбогдох байгууллагуудаас санал авсан. Энэ хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооноос дэмжсэн санал ирээд бас тодорхой хугацаагаар хойшлуулах нь зүйтэй. Энэ нь эргүүлээд хуулийг нэг мөр хэрэглэхэд. Цаашлаад Улс төрийн намын тухай хууль дээр орсон гол концепцын шинжтэй өөрчлөлтүүд байгаа л даа. Жишээлбэл, бүтэц зохион байгуулалтын хувьд.

Намын хөтөлбөр болон намын дүрмийг бүх гишүүдийн оролцоог хангаж байж хөтөлбөрт өөрчлөлт оруулах, батлуулах гэж.

Дээр нь анхан болон дунд шатны, дээд шатын намын бүтцийн байгууллагаар дүрэм болон хөтөлбөрийг хэлэлцүүлж энэ өөрчлөлтийг оруулах, батлуулах гэсэн ийм ийм чухал заалтууд байгаа.

Түрүүн гишүүдээс ярьж байсан. Санхүүжилт дээр асуудал үүсэх талаар.

Тэгэхээр төрөөс санхүүжилт олгох бол Сонгуулийн ерөнхий хороо гардан зохион байгуулахаар байгаа. Одоогоор энэ бүртгэлд орсон, ороогүй, дүрэм болон хөтөлбөрт өөрчлөлт орсон, ороогүй гэдгээс үл шалтгаалан улс төрийн намын тухай хуулийнхаа дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос зохион байгуулалтын ажлыг хийгээд одоогоор 7 нам дээр яах аргагүй шаардлага хангасан нам дээр санхүүжилтийг олгох бэлтгэл ажлууд хийгдээд явж байгаа.

Тэгэхээр энэ дээр ямар нэгэн санхүүжилт олгохгүй байх гэсэн ийм хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй. Энэ ажил хийгдээд явж байгаа юм билээ.

Улсын дээд шүүхэд одоогоор 7 нам бүртгүүлэх саналаа өгсөн боловч эндээс 2 нь буцаагдсан.

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: Энэ ингээд толгой эргүүлээд л худлаа яриад байх юм.

Энэ 38.7 дээр чинь байгаа шүү дээ.

Тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэж албан ёсоор үүнийгээ танилцуулна, байршуулна гээд. Ийм юм чинь байхгүй байна шүү дээ л гээд байгаа шүү дээ.

Дөрөв, таван санал байсан. Би уншсан. Иргэдийн, олон нийтийн. Эсэргүүцсэн байсан. Тэрийг яагаад энд тусгаж оруулж ирэхгүй байгаа юм бэ гээд л асуугаад байгаа шүү дээ.

Ингээд л толгой байнга эргүүлэх гэж оролдох юм. Энэ чинь бүгдээрээ тэнэг хүмүүс биш шүү дээ. Үүнийг чинь хараад л, уншаад л ойлгож байна шүү дээ. Нэгд.

Хоёрт, ер нь хуулийн засаглал гэдэг чинь төрийг дампуурч, төрийг эсвэл хэтэрхий хүчтэй байж, данхар байхаас нь хуулиар сэргийлэхэд зориулагдсан засаглал шүү дээ. Уг нь.

Төрийг буруу үйл ажиллагаа хийхээс нь сэргийлж хуулийн засаглал орших ёстой атал бид нар одоо ингээд буруу үйл ажиллагаагаа байнга хууль өөрчлөх замаар яваад байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Тодруулж нэмж хариулъя. Н.Жамъянхүү.

Н.Жамъянхүү: Ж.Баярмаа гишүүний асуултад хариулъя. Нэмж.

Хууль тогтоомжийн хуулиар тодорхой 38.6 дээр заасан байгаа. 38.7 дээр мөн гишүүний хэлж байгаагаар олон нийтийн хэлэлцүүлгийн дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналыг оруулна гэж байгаа.

Ингэхээр энэ цахим санал асуулгыг 11 сарын 05-ны өдөр явуулсан. 11 сарын 20-ны хугацаанд цахим саналаар санал ирээгүй. Үүний дараагаар Засгийн газраар хэлэлцсэний дараагаар цахим саналууд ирсэн учраас Хууль тогтоомжийн тухай хуулийнхаа дагуу тухайн саналууд нь авагдаагүй.

Өөрөөр хэлбэл хугацаа дууссанаас хойш. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш саналууд ирсэн байгаа.

Шаардлагатай бол надад хувилбарууд нь байгаа. Он, сартайгаа.

Д.Амарбаясгалан: Даваасамбуугийн Ганмаа гишүүн алга байна. Агваанлуvsангийн Ундраа гишүүн асуултаа асууя.

А.Ундраа: Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Улс төрийн намын шинэчлэл гэдэг парламентын засаглал, тэгээд ардчиллын бат бэх байдалд маш чухал үүрэгтэй.

Тэгэхээр Монгол Улсад бүртгэлтэй байгаа улс төрийн намууд Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн шинэчлэлт өөрчлөлтийг хийх, өөрсдийгөө дайчлан ажиллах нь зарчмын хувьд чухал учраас Монголын ард түмний сонголтод сонголт болж очиж байгаа намууд өөрсдөө сонголт шиг сонголт байхынх нь үндсэн суурь нь энэ хуулийн хэрэгжилт байгаа.

Тэгэхээр манай “Үндэсний эвсэл”-ийн зүгээс энэ хуульд нийцүүлэн өөрчлөлтүүдийг хийж, бас тодорхой алхмуудыг авч хэрэгжүүлсэн. Үндэсний эвсэл гэсэн аппликэйшн гаргасан. Энэ нь хэрэглэгдээд явж байгаа.

Мөн манай үүсгэн байгуулсан хоёр нам Монголын ногоон нам, Монголын үндэсний ардчилсан нам дүрмээ шинэчлэн Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр хүргүүлсэн байгаа.

Тэгэхээр “Үндэсний эвсэл”-ийн хувьд бас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, улс төрийн сонгох болон сонгогдох процесст эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцоог тэгш байлгах чиглэлээр тодорхой алхмуудыг авч хэрэгжүүлж, энэ дүрэмд нийцүүлэн аль аль хүйсийн төлөөллийг илүү тэнцвэртэй байдлаар төлөөлөх байдлаар хүргэсэн.

Бас нэр дэвшүүлэхдээ ч гэсэн Улсын Их Хурал, орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэх ажлыг бас тэгж хийсэн байгаа.

Тэгэхээр сая Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хэлж байна л даа. Жендэрээ баримтлах гээд. Энэ жендэр гэдэг үг зөвхөн эмэгтэй хүйс мэтээр ташаа ойлголт явдаг.

Гэтэл энэ бол аль ч хүйсийн асуудал. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрхийг хуулиар хангах тухай асуудал байгаа.

Тэгэхээр Хэрэг эрхлэх газрын даргыг бас энэ дээр зөв зүйтэй үг хэллэгээр яривал зүйтэй юм уу гэж бодож байна.

Тэгээд энэ хуулийн яг энэ заалтыг хэрэгжиж эхлэх хугацааг хойшлуулъя гэдэг дээр тодорхой жижиг намуудын зүгээс парламентад суудалгүй намуудын зүгээс санал гаргасан. Энэ дагуу хэлэлцэж байна гэж байна.

Гэтэл парламентад суудалтай эрх барьж байгаа нам, одоо ялангуяа Монгол Ардын нам, Ардчилсан нам энэ журамд нийцүүлэн дүрмээ шинэчлэх, их хурлаа хийх бүрэн бололцоотой. Нэгдүгээрт.

Тэгэхээр үүнийг би яг жинхэнэ шалтгаан биш шалтаг болгож ашиглаж байгаа юм уу гэж ийм байр суурьтай байна.

Тэгээд бүтэн 2 жил 10 сар юугаа хийх гээд их хурлаа хийж чадахгүй гэж ингэж далимдуулж хойшлуулах. 2027 оны 8 сар гэдэг чинь одоогоос тоолох юм бол бүтэн 2 жил 10 сарын хугацаа байгаа.

Тэгэхээр хэдийгээр хойшлууллаа ч гэлээ гэсэн энэ нь 6 сарын хугацаатай хойшлуулж болдоггүй юм уу? Тэр хооронд чинь маш олон цаг хугацааны заагууд байна шүү дээ.

Тэгэхээр Хэрэг эрхлэх газрын даргаас асуумаар байна. Энэ өргөн барьсан хуулийн хүрээнд яг энэ хэрэгжилтийг хойшлуулах хугацааны энэ логикийг ямар байдлаар ингэж тооцож гаргасан юм бэ? Та өөрөө бас сая хэлж байна. Намын дэргэдэх бодлогын судалгааны хүрээлэнгээ байгуулсан, бүртгэлээ шинэчилсэн зэрэг эдгээр асуудлуудаа хийчихсэн юм бол даруйхан хурлаа хийчих бэлтгэл чинь хангагдчихсан байгаа юм биш үү.

Тэгэхээр намуудын дотоод зохион байгуулалтын асуудал арай өөр учир шалтгаантай юм болов уу гэж тийм л дүгнэлтэд хүрэхүйц байна л даа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Монгол Улсын сайд Ням-Осорын Учрал хариулья.

Н.Учрал: Яах вэ одоо Улс төрийн намын хууль 01 сарын 01-нээс хэрэгжээд явж байгаа.

Тэгэхээр дүрэмтэй, хөтөлбөрөө хэрэгжүүлээд үйл ажиллагаагаа бүхий л намууд явуулж байгаа.

Энэ хууль бол түрүүн би хэлсэн. Хуулийн хэрэгжих хугацаа огт хойшлоогүй. Зөвхөн Улс төрийн намын хуулийг дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйл буюу улс төрийн намын хуулийн шалгууруудад нийцүүлээд шинээр дүрмээ, намаа Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хугацааг 7 дугаар сараас хойш 6 сарын хугацаанд бэлтгэл ажлыг хангаад дээд шүүхэд 30 хоногийн дотор бүртгүүлнэ гэдэг энэ хугацааг сунгах асуудлыг ярьж байгаа юм.

Тэгэхээр ер нь хууль огт хойшилж байгаа ойлголт биш гэдгийг бас хэлэх ёстой.

Тийм учраас түрүүн гишүүд ч гэсэн хөндөөд байсан. Одоо намууд өөр өөрийн дүрэмтэй.

Тэгээд дүрмээ хэрэгжүүлээд л явж байгаа. Дээрээс нь сая гэхэд л Улсын дээд шүүхээс мэдээлэл авахад 7 нам дүрмээ шинэ хуульд нийцүүлэхээр эхнээсээ илгээгээд эхэлчихсэн байна.

Гэхдээ мэдээж энэ дээр Улсын дээд шүүхээс бүртгүүлэх материал дээр хангагдаагүй бичиг баримтуудын бүрдүүлбэр дутуу юмнууд байна гэдгийг бас илэрхийлээд шалгаад явж байгаа юм байна.

Намын их хурал хийх асуудал намын дотоод асуудал. Энэ сунгалаа гээд заавал энэ хуулийн хугацаанд нь тааруулаад жилийн дараа, 2 жилийн дараа бүртгүүл гэсэн ойлголт биш шүү дээ.

Үнэхээр материал нь бүрдчихсэн, шаардлагуудаа хангачихсан бол оны өмнө бүртгүүлээд л явна. Жишээ нь, парламентад суудалтай зарим намууд ч гэсэн их хурлаа төлөвлөчихсөн байгаа л гээд л хэлж л байгаа.

Дээрээс нь шинэ хуулийнхаа дагуу эхнээсээ 7 нам бүрдүүлдэгтэй адилхан энэ нэмэгдээд л явах юм байна лээ.

Зүгээр энэ улс төрийн намын хуулийг хэрэглэх буюу яг эрх ашиг сонирхол нь хөндөгдөөд байгаа оролцогч нар гээд байгаа энэ улс төрийн намуудад бид энэ асуудлыг энэ намуудаас саналыг нь сонсохоос өөр арга зам байхгүй шүү дээ.

Тийм учраас энэ парламентад суудалгүй намуудаа ингээд яриад байгаа юм.

Гэхдээ бид нэг зүйл дээр арай хатуу ойлгох ёстой. Улс төрийн намын хууль шаардлага өндөртэй хууль болсон. Намыг бодлогын институт болгох, санхүүжилтийг нь ил тод байлгахад маш том шинэчлэл болсон. Энэ хуулийг яг хэдий хугацаанд парламентад суудалгүй намууд хэрэгжүүлж чадах юм. Их Хурлын ажлын хэсэг дээр хэлэх хэрэгтэй.

Үнэхээр 6 сарын дотор, жилийн дотор хэрэглэж чадна гэдгээ та нар хариуцлагатайгаар хэлээд энэ хугацаандаа энэ бүртгэлээ дүрмээ нийцүүлэх ёстой. Үгүй бол нэг л арга зам байгаа. Институт болж чадахгүй байгаа, үйл ажиллагаа явуулахгүй байгаа, хааяа хурал зөвлөгөөн хийдэг идэвхгүй ийм намуудыг мэдээж татан буулгах, нэгтгэх нийлүүлэх энэ ажлууд хуулийнхаа дагуу л хийгдэх ёстой шүү дээ.

Түүнээс биш ингээд бас гишүүдийн хэлж байгаа үнэн.

Тийм учраас парламентад суудалгүй намууд өөрсдөө хугацаагаа ингэж л.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Цаг хугацаа, хариуцлага гэдэг хоёр юмны талаар ярих ёстой гэж би бодож байгаа.

Улс төрийн нам гэдэг чинь өөрөө цэцэрлэг биш, эсвэл нэг хувийн компани биш. Цүнхний компани гэдэг шиг нэг ийм цүнхний намуудаа хэвийн ажиллуулахын тулд хүлээх шаардлага байхгүй гэж бодож байгаа.

Тэгээд энэ чинь цэцэрлэг биш учраас, эсвэл хувийн компани биш учраас намд байх ёстой, намд хийгдэх ёстой ажлуудаа хугацаандаа хийгээгүйнх нь төлөө хуулийн шаардлага хангаагүй, хариуцлагагүй 5-аас 7 намын ирүүлсэн хүсэлтээр үүнийг хойшлуулах гээд байх шиг байгаа юм.

Гэтэл 37 намтай Монгол Улс яагаад 5-аас 7 нам хариуцлагагүй намаас болж бүхэл бүтэн хуулийн хэрэгжих хугацаа, тэр дүрмийнх нь хэрэгжих хугацаа энэ тэрийг нь хойшлуулах гээд байгаа юм.

Цаг хугацаа чинь энэ хариуцлагагүй намуудаа хүлээгээд эмнэлгийн орон дээр сэхээнд байгаа хүнтэй адил хүлээж чадахгүй шүү дээ. Энэ цаг хугацаа чинь. Яг цаг хугацаандаа хэрэгжүүлээд л явмаар байна гэдэг ийм асуулт, байр суурь гэх юм уу.

Тэгээд энэ хариуцлагатай байсан намууд нь яана гээд ингээд хүлээгээд бусдыгаа хүлээгээд нэг дүргүй бух шиг байх гээд байх шиг байна.

Тэгээд жишээлэхэд Ардчилсан нам хариуцлагатай нам. Хариуцлагатай нам учраас одоо энэ улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөөд, дүрмээ шинэчлээд, биелүүлээд илүү сайхан маргаашийн төлөө ажилламаар байна гэж.

Хоёрдугаарт нь, эрх баригч нам өмнө нь аливаа хуулийг батлахдаа тодорхой хэмжээнд судалгаа хийдэг, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлдэг, судалгаа авдаг гэж ойлгоод байгаа.

Гэтэл эрх баригч нам маань өмнө нь энэ хуулиа баталж байхдаа судалгаа хийгээгүй, санал хүсэлт аваагүй хууль баталдаг байсан гэсэн үг юм уу, эсвэл хэт олонхдоо найдаад бусад намуудаа тоогоогүй, судалгаа, шинжилгээ аваагүй хийчихсэн гэсэн үг юм уу? Ийм хоёр асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Хууль тогтоомжийн хуулийн дагуу хуулийн төслийг боловсруулсан гэж би ойлгож байгаа.

Яагаад гэхээр Хууль зүй, дотоод хэргийн яам боловсруулсан хууль. Үзэл баримтлал, танилцуулга дээр нь Хууль зүй, дотоод хэргийн яам хууль тогтоомжийн бүрдүүлбэрийг хангасан эсэх асуудлаар өөрсдөө тандан судалгаагаа хийгээд Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Яамдаас санал авсан.

Хамтарсан Засгийн газар хамтаараа шийдвэр гаргаад Засгийн газар Их Хуралд Улс төрийн намын хуулийн дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйлийг өөрчлөх энэ хуулийн төслийг танилцуулж байгаа.

Яагаад ийм хэрэгцээ шаардлага үүссэн юм бэ гэхээр одоогоор энэ чинь 9, 10 нам болчихоод байна л даа. 10 нам нь хүсэл шаардлага ирүүлсэн. Парламентад суудалтай 3 намын дарга Засгийн газарт ажиллаж байна.

Тэгээд эдгээр намууд хүсэлтээ ирүүлсэн. Парламентад суудалтай Иргэний зориг ногоон нам албан ёсоор хүсэлтээ илэрхийлж, байр сууриа илэрхийлсэн. Ингээд л хэрэгцээ шаардлага үүслээ.

Ингээд хууль тогтоомжийн хуулийн дагуу тандан судалгаагаа хийлээ. Мэдээж Улс төрийн намын хууль чинь ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа оролцогч нарын байр суурийг сонсох ёстой л доо.

Тэр утгаараа улс төрийн намууд л байр сууриа илэрхийлсэн учраас явж байгаа.

Түүнээс хуулийн хэрэгжих хугацаа хойшлоогүй. Тэр хоёр жил гээд хугацаа яагаад тавьсан юм бэ гээд байгаа гэхээр энэ парламентад суудалгүй намууд өөрсдөө нэг ийм хугацааг л тавивал энэ хугацаанд ингээд яг институц болтлоо бэлтгэл ажлаа хангаад, дүрмээ бүртгүүлээд явчихъя гэдэг ийм л хүсэлтийг тавьсан юм билээ.

Тэгээд ийм хэлбэрээр тавьснаас Их Хурлын ажлын хэсэг энэ хугацааг нь багасгаад явах хэрэгтэй. Тэгэхдээ одоо манай улс төрийн намууд дахиж одоо ийм хариуцлагагүй байж болохгүй. Парламентад суудалгүй намууд хэлэх хэрэгтэй.

Бид үнэхээр 6 сарын дотор дүрмээ бүртгүүлж чадна гэвэл ингээд явах хэрэгтэй. Тэгэхгүйгээр хурлаа хийж чадахгүй байна. Цаг хугацаа байсангүй. Яг үнэндээ бас энэ Их Хурлын гишүүдийн хэлээд байгаа зөв л дөө.

Гэхдээ бид ингээд сарын хугацаанд шууд хатуу ингээд хэрэгжүүлээд явчихъя гэхээр дээд шүүхэд нэгэнт тайлбар ирүүлээд бүртгэхгүй байж болзошгүй шүү. Материал чинь дутуу гэхихсэн байдаг.

Тэгээд явж байтал нэг сард 37 улс төрийн намаас 30 улс төрийн нам нь татан буугдаад Үндсэн хуулийн маргаан үүсэх вий дээ. Эвлэлдэн нэгдэх эрх эрх чөлөөг нь хангуулсангүй. Суудалгүй намууд чинь Та бүхэнд ямар зовлон зүдгүүр

гай тарчиг учруулчхаад байгаа юм бэ гээд л өчигдөр Байнгын хороон дээр яриад байна л даа.

Тэгэхээр Монгол Улс чинь бас ардчилсан улс.

Тэгээд тал бүрийн байр сууриудыг сонсох ёстой. Төрийн байгуулалтын байнгын хороо бас ажлын хэсгээ байгуулах үеэрээ энэ парламентад суудалгүй намуудын саналуудыг сонсоод хугацааг багасгах ёстой. Түүнээс хойш дахиж янз бүрийн асуудал ярих бололцоогүй шүү. /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин асуулт асууна.

Б.Түвшин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэ хэлэлцэж байгаа асуудлын талаар гурав, дөрөвхөн асуулт байна.

Нэгдүгээрт, одоо хүчин төгөлдөр хэрэгжээд явж байгаа хуулийн тодорхой заалтуудыг хойшлуулж байгаа нь өөрөө Үндсэн хууль зөрчиж байгаа асуудал биш үү? Энэ Үндсэн хуулийн зөрчил рүү орох уу гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаар асуудал. Энэ гаргасан хуулийн хүрээнд бичиг баримтаа бүрдүүлж өгч чадахгүй байгаа дээр ямар санкц байгаа юм бэ? Миний харж байгаагаар ямар ч санкц, хариуцлага байхгүй.

Тийм учраас хэрвээ үүнийг нь хойшлуулж байгаа бол тэр Улс төрийн намын тухай хуулийн дагаж мөрдөх журмын 3 дахь хэсэг буюу тэр санкцын тэр төрөөс өгөх дэмжлэг юм биш үү.

Гуравдугаарт, ерөөсөө гол асуудал нь 21 дүгээр зүйл дээр байж байгаа асуудлыг заавал ингэж хууль өөрчилж шийдэх шаардлага байгаа юм уу?

Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйл. Тэр дотроо 21.3 дээр ямар нэгэн байдлаар хуралдуулаагүй бол бүртгэхгүй. Бүртгэхгүй бол 21.4-өөр бичиг цаас нь бүрэн болсны дараа 60 хоногийн дотор дээд шүүх бүртгэнэ л гэчихсэн.

Тэр санкцаараа л явчхаж болдоггүй юм уу? Заавал үүнийг ингэж хууль өөрчилж, хэрэгжиж байгаа хуулийн тодорхой заалтуудыг өөрчилж хэрэгжүүлэх гээд байгаа шалтгаан нь юу юм.

Гуравдугаарт, 2.8 жил, 2 жил 8 сар гээд байгаа. Энэ 2 жил 8 сар дээр ямар судалгаа авсан юм. Яагаад энэ бичиг цаас бүрдүүлэхэд 2 жил 8 сар хэрэгтэй болсон юм гэсэн ийм хэдэн асуултад хариулж өгөөч ээ.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс Хууль зүйн яамны Н.Жамъянхүү дарга.

Н.Жамъянхүү: Б.Түвшин гишүүний асуултад хариулъя.

Энэ улс төрийн намын тухай хууль дээр хэд хэдэн том концепцын өөрчлөлтүүд орсон байгаа. Одооэнэ 2024 оны 01 сарын 01-нээс эхлээд мөрдөж эхэлж байгаа хууль дээр зааж. Тухайлбал тогтолцоо, бүтцийн өөрчлөлт байгаа. Нэгжийн.

Хоёрдугаарт нь, гишүүдийн оролцоог энэ дүрэм, хөтөлбөрийг өөрчлөх тал дээр оролцоог хангах гэсэн байдаг.

Яах вэ хэлбэрийн хувьд төлөөллийнхөн байх юм уу, бүр анхан шатнаасаа эхлэх юм уу гэдэг нь тухайн намын дотоод дүрмээрээ зохицуулах асуудал.

Нэг том гол өөрчлөлт бол энэ Үндсэн хуулийн 19.1 штрих дүгээр зүйлд заасан бас энэ улс төрийн намтай холбоотой гол өөрчлөлт байгаа. Энэ дээр Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10-д заасны дагуу байгуулагдаж улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана гээд намыг ингээд заачихсан.

Хоёр дахь хэсэгт нам Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэний нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна гээд заачихсан.

Өөрөөр хэлбэл одоогоор 21 мянга гаруй иргэд байгаа. Энэхүү заалтыг ёстой 2028 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гээд заачихсан.

Дагаж мөрдөх Үндсэн хуулийн энэ заалтыг 2028 оны 01 сарын 01-нээс дагаж мөрдөхөөр заасан. Үүнтэй уялдуулаад мөн адилхан энэ журмын хугацааг тодорхой хэмжээгээр хойш нь 2027 он гэж оруулж.

Гэхдээ энэ 2027 оны 8 сарын 01 гэдэг бол хамгийн сүүлчийн хугацаа.

Улс төрийн намууд ч гэсэн өнөөдөр Улсын дээд шүүхээс өчигдрийн авсан мэдээгээр 7 нам ирүүлсэн байна гэж байгаа. Дүрэм болон хөтөлбөртөө өөрчлөлт оруулаад.

Энэ хугацаанд сарын дараа юм уу, 2 сарын дараа, 6 сарын дараа, 3 сарын дараа намууд бүртгүүлэхээр хүсэлтүүдээ, дүрмээ өөрчлөлтүүдээ оруулж ирж болно. Энэ хамгийн сүүлийн хугацаа байгаа юм.

Одоогоор Улсын дээд шүүхэд нийтдээ 7 нам ирүүлсэн байгаа. Дүрэм, хөтөлбөртөө өөрчлөлтөд оруулахаар. Энэ хугацааг нь авч үзэх юм дандаа 11 сарын 15, 17, 27, 25-ны өдрүүдэд ирүүлсэн байгаа.

Өөрөөр хэлбэл энэ хууль Засгийн газраар хэлэлцэж эхлэхээс эхлээд л улс төрийн намууд Улсын дээд шүүхэд яг энэ дүрмийнхээ өөрчлөлтийг бүртгүүлье гээд ирүүлсэн байгаа юм.

Тэгэхээр энэ хэрэгжиж эхлэх хугацаа нь 07 сарын 07-ноос эхэлж байсан боловч улс төрийн энэ 7 нам 11 сарын арван хэдэнд өгсөн байгаа байхгүй юу.

Дараагийн нэг асуудал нь энэ улс төрийн намуудаас 7 нам ирүүлсэн байгаагаас 2 нь шаардлага хангахгүй гээд нэг нь бүртгүүлээгүй. Хоёр дахь нь бичиг баримт.../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж тодруулъя. Асуултад нь маш тодорхой хариулаарай.

Ийм их хугацаа хэрэгтэй юм уу гээд 4 асуулт асуусан шүү дээ. Б.Түвшин гишүүн тодруулъя.

Б.Түвшин: Тэгэхээр яг явж байгаа хуулийн тодорхой заалтуудыг өөрчилж байгаа нь Үндсэн хуулийн зөрчил рүү орох эрсдэлтэй байна гэж би хувьдаа дүгнэж байна. Асуулт хариулаагүй учраас. Энэ дээр надад тодорхой хариултыг бичгээр ирүүлээрэй.

Хоёрдугаарт, ерөөсөө тэр 01 сарын 01-нээс эхэлж мөрдөх, 01 сарын 01-нээс эхэлж тэр шинээр бүртгүүлэх шаардлага хангаагүй намууд тэр улс төрийн намын санхүүжилтийн дэмжлэг авах шаардлагагүй юм байна.

Энэ нь өөрөөр хэлбэл 21 дүгээр зүйлийн идэвхгүйд тооцох юм байна. Цаашдаа ч гэсэн улс төрийн намууд хааяа бүртгэлээ хийхгүй хоцроод л явбал идэвхгүйд тооцогдож байгаад л тэгээд л шаардлагаа хангасан үед идэвхтэй болоод л бүртгүүлээд л 60 хоногийн дотор дээд шүүхээс бүртгэлээ аваад л явах юм байна шүү дээ.

Тэгээд ингээд хэвийн явж байгаа зүйл дээр заавал ингэж энэ хуулийн заалтыг өөрчилж хойш татах шаардлагагүй юм байна гэж би таны хариултаас тэгж дүгнэлээ.

Гуравдугаарт, яг тэр 2.8 жилийн талаар яг тодорхой.../минут дуусав/

Х.Булгантуяа: Н.Жамъянхүү дарга нэмж хариулъя.

Н.Жамъянхүү: Үндсэн хуулийн зөрчлийн асуудал Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хууль зөрчөөгүй гэдэг байдлаар бид Улсын Их Хурал хэлэлцүүлэх зөвшөөрлөө олгосон.

Мөн Улсын Их Хурлын Тамгын газраас энэ хуулийн төслийг хууль тогтоомжийн шаардлага хангасан, мөн хуулийн зөрчилгүй гэж үзэж хэлэлцэж байгаа. Өнөөдрөөр.

Харин Үндсэн хуулийн зөрчлийн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэц эцэслэн шийдвэрлэх. Зөрчиж байна уу эсэх асуудлаар шийдвэр гаргах эрх хэмжээтэй байгууллага.

Хоёр дахь асуудалд нь яагаад ийм урт хугацааны байгаа юм бэ гэдэг. Би түрүүн тайлбарласан. Үндсэн хуулийн 19.1 штрихийн 2 дахь хэсэг дээр яах аргагүй нөгөө иргэдийн 1 хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна гээд тодорхой заачихсан.

Өөрөөр хэлбэл улс төрийн намын тодорхой шаардлагуудыг маш өндөр болгож энэ шинэ.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын Жуковын Алдаржавхлан.

Ж.Алдаржавхлан: Баярлалаа.

Улс төрийн намын хуулиар 2025 оны 01 сарын 01-нээс өмнө дүрмээ шинэчилсэн байх ёстой гэсэн заалт байгаа. Шинэ хуулиар. Тэгээд үүнийг хойшлуулах асуудал орж ирж байгаа юм байна.

Надад нэг, хоёрхон асуулт байна. Н.Учрал сайд аа, хоёрхон асуулт байна.

Хэрвээ энэ хугацаанд дүрмээ шинэчлэхийг нь хойшлуулчих юм бол санхүүжилтийг нь хамтад нь хойшловол яасан юм бэ гэж байгаа юм.

Санхүүжилтийн асуудал. Улсын төсвөөс өгдөг тэр дэмжлэг санхүүжилтийг нь хойшлуулах асуудлыг хамтад нь оруулж ирвэл яасан юм бэ?

Дотроо дүрэм журмаа шинэчилж чадахгүй байгаа, дотроо учраа олохгүй байгаа нөхдүүдэд төсвөөс санхүүжилт өгөхөөр эргээд улсын хөрөнгийг үрэн таран хийх юм биш биз дээ.

Тийм учраас ажлын хэсэг дээрээ Та бүгд яриад нэгэнт хугацааг нь хойшлуулж байгаа бол. Хугацаа ойл хойшлуулж байгаа хэрэгцээ шаардлагыг ойлгож байгаа. Энэ санхүүжилтийнх нь хэсгийг нь хамтад нь хойшлуулаад, тэгээд дүрэм журмаа шинэчилсэн намууд нь санхүүжилтээ авах эрх нь нээгддэг, дүрэм журмаа шинэчилж чадахгүй байгаа нөхдүүд нь тэгээд санхүүжилтээ авдаггүй байвал яасан юм бэ. Ийм асуулт байна. Энэ дээр нэг хариулж өгөөч ээ гэж хүсэж байна.

Х.Булгантуяа: Н.Учрал сайд асуултад хариулья.

Н.Учрал: Тийм. Ер нь одоо тэгээд улс төрийн намынхаа хуулийн шаардлагад нийцүүлээд дүрмээ шинэчилж чадахгүй байгаа, намын гишүүдийнхээ оролцоог хангуулж чадахгүй байгаа, институц болж бүрэлдэж чадахгүй байгаа намууд цаашаа байх уу, үгүй юу гэдгийг ярих хэрэгтэй.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүдийн байр суурь маш зөв. Улс төрийн намуудын тэр санхүүжилтийн асуудал дээр өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан нам, эвсэлд санхүүжилт олгодог.

Одоогийн байдлаар 7 нам, эвсэл санхүүжилт авах буюу 1 хувийн босго давсан. Бусад парламентад суудалгүй намуудын хувьд санхүүжилтийн ойлголт байхгүй шүү дээ. Зөвхөн 7 намын асуудал. Одоо 1-ээс дээш давсан.

Одоо парламентад суудалтай нам, эвслүүд дээрээс нь Шинэ нэгдсэн эвсэл, Үнэн ба зөв гэсэн намууд 1 хувийн босго давсан юм билээ. Бусад намуудын хувьд ямар нэгэн байдлаар санхүүжилт авч байгаа зүйл огт байхгүй.

Тэгэхээр Их Хурал дээр ажлын хэсгээ байгуулаад, энэ улс төрийн намуудыг оролцуулаад, тал бүрийн байр сууриудыг нь сонсоод хугацааг бас наашлуулах, хаана хаанаа эрх, үүргээ ухамсарлаад хариуцлагатай ажиллах чиглэлээр Их Хурал мэдээж манлайлж ажиллаад энэ хуулийг нэг талд нь гаргаад, тэгээд түүнээс хойш дүрмээ шинэ хуулийн дагуу нийцүүлээгүй бол, үнэхээр л хуулиа хэрэгжүүлээгүй бүртгэх эсэх асуудал мэдээж Улсын Дээд шүүхийн асуудал шүү дээ. Гэдэг ийм л зүйл байгаа юм.

Х.Булгантуяа: Ж.Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Би ажил хэрэгч санал гаргаж байгаа шүү. Ажлын хэсэг дээрээ манай Их Хурлын бүрэлдэхүүн ярина биз дээ.

Хэрвээ дүрмээ шинэчилж чадахгүй бол санхүүжилтийг нь давхар хойшлуулах саналыг гаргаж байгаа. Үүнийг манай Засгийн газрын зүгээс дэмжиж өгөөсэй гэж хүсэж байгаа юм.

Яагаад гэхээр дүрмээ шинэчилж чадахгүй байна гэдэг чинь тэнд байна гэдэг чинь тэнд дандаа хариуцлагагүй нөхдүүд л байгаа байхгүй юу. Улсаас хөрөнгө авах ямар ч бололцоогүй улсууд байна л гэж үзэж байгаа юм.

Ер нь тэгээд улс төрийн намуудад төсвөөс санхүүжилт өгөөд сайн сайхан болчихно гэхэд би л лав итгэхгүй л байгаа юм.

Гэхдээ ямар ч байсан хууль батлагдчихсан юм чинь. Хэрвээ 2027 он хүртэл дүрмээ шинэчилж чадахгүй бол түрүүлж Их Хурлаа хийж, түрүүлж намынхаа дүрмийг шинэчилсэн намуудад нь тэр санхүүжүүлэх эрх нь нээгддэг л байх ёстой.

Тэгээд шинэчилж чадахгүй, нам дотроо учраа олж чадахгүй, хурлаа хийх гэхээр асуудал үүсчих гээд байгаа бол тэр хүмүүс хариуцлагагүй, чадваргүй улсууд байна л гэсэн үг.

Тийм учраас санхүүжилтийг нь бас давхар хойшлуулах ёстой л гэсэн би тийм үзэл санаатай байна.

Х.Булгантуяа: Ж.Алдаржавхлан гишүүн их зөв санал хэлж байна шүү. Ажлын хэсгийнхэн маань анхаараад. Төсвийн мөнгө хариуцлагатай зарцуулагдах ёстой.

Тийм учраас хариуцлагатай нам, улс төрийн байгууллагад л олгогдох ёстой гэдэг саналыг хэлж байна.

Дамбын Батлут гишүүн. Д.Батлут гишүүн байхгүй байна. Очирбатын Амгаланбаатар гишүүн. Байхгүй байна. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн.

А.Ганбаатар: Тийм. Өнөөдөр орж ирж байгаа Улс төрийн намын тухай хууль Шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах энэ талыг хойшлуулъя гэдгийг дэмжиж байгаа.

Учир нь юу гэхээр олон нам зэрэгцэн орших, дээр нь олон ургалч үзлийг дэмжиж байгаа Үндсэн хуулиараа бид ардчилсан байдлаар хандаж байгаа бол энэ тодорхой санал гаргасан намуудын үндэслэлийг нь хүлээж авах ёстой.

Тэгээд энэ хуульд чинь бас зохицуулагддаг маш олон юм байж байдаг. Тухайлбал, сонгууль болохоор сум дээр, баг дээр нэг айл эхнэр, нөхөр хоёр хүртэл талцаад явж байдаг тал ч байдаг.

Тэгэхээр анхан шат дээр намын гишүүнчлэлийг нь яах ёстой юм. Тийм ээ. Хатуу гишүүнчлэл байх ёстой юм уу, үгүй юм уу гэдгээс авхуулаад хэрвээ гэр бүлийн анхны нэгж, нийгмийн анхны нэгж гэж үзэх юм бол улс төрөөс болж, Улс төрийн намын тухай хуулиас болж, намд элссэнээсээ болж тэнд асуудал үүсдэггүй баймаар байх жишээтэй.

Хугацааны хувьд ажлын хэсэг дээр бодитой санал гарах юм шиг байна. Тодорхой хугацаагаа тэндээ тавьчих байх.

Тэгэхээр энэ дээр эргэж харах зөндөө асуудлууд байгаа учраас улс төрийн намуудын санхүүжилтийн асуудлыг ч гэсэн эргэж харах ёстой.

Тийм учраас үүнийг хэлэлцье. Гэхдээ хугацааны хувьд хойшлуулсан нь зүйтэй гэдэг байр сууриа дахин илэрхийлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Санал хэллээ. Тийм ээ. Дашдондогийн Д.Ганбат гишүүн.

Д.Ганбат: Ингээд энэ хууль уг нь юу шүү дээ. Бид бүхэн Улсын Их Хурал хууль баталж, хууль тогтоож, тэрний хэрэгжилтэд хяналт тавьдаг ийм байгууллага л даа. Ард түмнээ төлөөлөөд. Засгийн газар маань хууль хэрэгжүүлдэг газар.

Гэтэл энэ Хууль тогтоомжийн тухай хуульд яг би хуулийг үг үсгээр нь уншаад өгчихье л дөө. 41.10.хуулийг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс хойш тухайн хууль болон түүний зүйл, хэсэг, заалт, дэд заалтын дагаж мөрдөх хугацаанд өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн мэдүүлэхгүй ээ л гэж байгаа юм.

Ямар нэгэн салаа утга байхгүй. Улс төрийн намын тухай хууль, Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулахад энэ үгс, үг үсэг, хугацаа, хоног, хугацаа бүх юм орно.

Гэтэл яагаад Засгийн газар энэ хуулийг зөрчөөд өргөн мэдүүлж байна. Яагаад Улсын Их Хурал тэрийг нь хүлээж авч хэлэлцэж байна. Эд нар чинь ингээд бүгд л хууль зөрчөөд байна шүү дээ.

Энэ хуулийн зүйл, заалтыг ойлгохгүй байгаа юм уу? Яагаад хуулиа дагаж мөрдөхгүй байна.

Улс төрийн намын тухай хууль маань өөрөө 1991 оноос хойш өөрчлөлт ороогүй явж байгаад Монгол Улсын Ерөнхийлөгч өргөн бариад 2023 оны 7 сарын 07-нд баталсан.

Хуулийн ажлын хэсэгт миний бие орж ажиллаж байсан. Олон намууд орж, зөвшилцөж, нэлээн нягт нямбай хэлэлцэж их хоног хугацаа зарж ингэж энэ хуулийг баталсан.

Энэ хууль маань өөрөө 2024 оны 01 сарын 01-нээс эхлээд хэрэгжээд явж байгаа. Үүний дараа сонгууль болсон. Ард түмэн ирж сонгууль өгөхдөө энэ Улс төрийн намын тухай хууль хэрэгжиж байгаа юм байна. Хэрэгжинэ гэж бодож сонгууль өгсөн байгаа.

Гэтэл Засгийн газраас энэ хуулийг хойшлуулна гэж ингэх нь болохгүй л дээ. Хуулийг зөрчиж. Үүний цаана ямар утга учир юу, байгаа юм бэ? Тэр тусмаа энэ хуулийг өргөн барьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх 2028 оны 7 сарын сүүлээр дуусна.

Гэтэл яг 8 сарын 01 гэж байгаа юм. Хугацааг нь ч хойшлуулж болохгүй. Улсын Дээд шүүх дээр 7, 8 нам бүртгүүлэх гээд өгчихжээ. Зарим нь бүртгүүлчхэж байгаа байх.

Үгүй ээ, тэгээд Улсын дээд шүүх чинь тэр бүх материалуудыг нь хүлээж аваад хэзээ яахыг нь засаж залруулахыг нь зааж өгөөд ингээд л явна шүү дээ. Ингэхгүй гэж бодоод байгаа юм уу? Үүний цаана юу байгаа юм бэ?

Ер нь намын дарга нар, намын удирдлага энэ бүх зүйлээ хууль журамдаа нийцүүлээд намынхаа дүрмийг, хөтөлбөрийг, зохион байгуулалтаа намынхаа гишүүдтэйгээ ярилцаад явахад юу нь болохгүй болчихоод байгаа юм.

Яагаад энд дургүйцээд байгаа юм.

Хамгийн төлөвшсөн гэж яриад байдаг институц болчихсон гэдэг Монгол Ардын нам маань Та бүхнийг чинь ингээд олон дагуул намтай болчихлоо. Охин намтай болчихлоо. Ингээд намуудыг дарга нарыг тавьж өгдөг болчихлоо гээд байна л даа. Шүүмжлэл тэгж явж байна.

Энэ чинь энэ хоёр том гүрний дунд оршиж байгаа манай Монгол Улсын хувьд аягүй энэ улс орныг эмзэг байдалд оруулж байна шүү дээ.

Бид олон намтай байх энэ замыг сонгочихсон.

Х.Булгантуяа: Н.Учрал сайд хариулах уу?

Н.Учрал: Улс төрийн намын хуулийг дагаж мөрдөх журмын хууль гээд хууль байгаа. 5 зүйлтэй. Тэр 5 зүйлийн 2 дугаар зүйлдээ нэмэлт, өөрчлөлт оруулах л ийм хуулийн төсөл.

Түүнээс биш Улс төрийн намын хуулийг дагаж мөрдөх хугацаа 2024 оны 01 сарын 01-нээс эхлээд хүчин төгөлдөр мөрдөгдөөд эхэлсэн.

Хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулаад 7 дугаар сараас 6 сарын хугацаанд намынхаа дүрмийг, үйл ажиллагааг шинэ хуульд нийцүүлэх арга хэмжээг аваад 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтээ улс төрийн намууд илгээх Улс төрийн намын хуулийн дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйл дээр Улсын дээд шүүхэд чиглэл болгосон дагаж мөрдөх журмын хууль байгаа юм.

Түүнийг л хөндөж байгаа болохоос биш хуулийн хугацаа хөндөж байгаа, эсвэл хуулийн хугацааг нь хойшлуулж байгаа огт ойлголт биш.

Тэгэхээр намыг үүрэгжүүлсэн заалт байхгүй юу. Жишээ нь, намууд дээд шүүхэд шинэ хуулийнхаа дагуу дүрмээ нийцүүлнэ шүү. Шинээр бүртгүүлнэ шүү

гэдгийг намуудыг үүрэгжүүлсэн дагаж мөрдөх журмын хуулийн тэр 2 дугаар зүйл яваад байгаа.

Тэгээд тэр 2 дугаар зүйл дээр л нэмэлт, өөрчлөлт оруулах гээд байгаа ийм л хууль.

Тийм учраас хууль зөрчиж байгаа гэж шууд ойлгож ерөөсөө болохгүй. Яагаад гэхээр энэ бол улс төрийн намын хуулийн хугацаа хойшилж байгаа агуулга огт биш шүү гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Д.Ганбат гишүүн нэмж тодруулъя. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ дарга.

Ж.Бат-Эрдэнэ: Хугацаатай холбоотой асуудлуудыг ярьж байгаа. Ер нь Байнгын хороон дээр ч бас яригдсан.

Тэгэхээр хэлэлцэх эсэхээ бид өнөөдөр ингээд шийдэх байх. Үүний ар дээр хэрвээ хэлэлцээд явах тохиолдолд ажлын хэсэг гарч болно. Эсвэл хэлэлцэх явцад Байнгын хороон дээрээ бид зарчмын зөрүүтэй саналаар хугацаатай холбоотой саналуудыг гаргаж болно.

Ер нь ажлын хэсэг гарах байх гэж бодож байна. Ажлын хэсэг гараад 2 намаас, 3 намаас, одоо хэдэн нам байдаг юм. Энэ парламентад байгаа 5 намаасаа бүрэлдэхүүнээ оролцуулаад ажлын хэсэг байгуулаад, тэгээд энэ дээрээ хугацаагаа харж байгаад заавал 2027 он.

Байнгын хороон дээр 2026 оны 01 сарын 01 ч гэж орж ирсэн саналууд бас гарч байсан. Тийм болохоор үүнийг 2026 оны 7 сар. Яг үүгээр нь 8 сард нь ч байдаг юм уу, эсвэл бүр нэ 2026 оны 01 сарын 01-нээр ч байдаг юм уу ингээд ажлын хэсэг дээр цаг хугацааг нь ярьж хэдүүлээ баталж болно.

Х.Булгантуяа: Ж.Бат-Эрдэнэ гишүүнд нэмж минут өгье.

Ж.Бат-Эрдэнэ. Бид Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад олон намын тогтолцоо руу орсон.

Энэ яах гэж үүнийгээ бид хийсэн юм гэхээр үндсэндээ урьд өмнө зөвхөн 2 нам. Нэг нь ялдаг. Гөгөөдөх нь цөөнх болдог. Нөгөөдөх нь ялдаг, нөгөөдөх нь эргээд цөөнх болдог гээд ингээд л 30 жил өнгөрлөө шүү дээ. Бид нар.

Тэгэхээр үүнийгээ больё. Олон намын тогтолцоо руугаа оръё. Ардчилал, дээр шударга ёс юмнуудаа ил тод хэлдэг зүйлүүдээ ил тод болгоё. Олон намын тогтолцоотой байж бид хяналтын систем маань сайжирна. Энэ үүднээс бид намуудаа дэмжих өнцгөөс нь өнөөдрийн энэ орж ирж байгаа юм шүү.

Түүнээс биш нам олон болчихлоо. Эхнээс нь цаг хугацаагаар нь хавчаад тэгээд хасаад багасгаад, юу гэдэг юм тэр янз янзын нэр өгөөд байгаа Гудамжны нэр ч гэдэг юм уу, юу гэдэг юм. Тэр намуудаа шахъя гэсэн ийм өнцгөөс бид харж болохгүй шүү дээ.

Энэ парламентыг бид олон намтай болоосой гэж хүссэн. Харин ч бүр 5 намтай ардчилсан ийм парламентад бий болж байгаа шүү дээ. Бид нарт.

Тэгэхээр тэр утгаараа намуудаа бид.../минут дуусав/

Х.Булгантуяа: Д.Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Үгүй ээ үгүй. Та нар намыг бойжуулаад. Тийм ээ. Тэгээд байдаг ч хүмүүс биш л дээ. Монголын ард түмэн л мэдэх байх л даа. Яах ийхийг нь. Тэрийг шийдчихсэн гэж ойлгоод байгаа.

Тэгээд энэ дээр чинь өргөн барихгүй ээ гэхчхэн байна шүү дээ. Энэ хуулийн зүйл, заалт дээр.

Тэгээд яагаад энэ хуулийн зүйл, заалтыг зөрчөөд байгаа юм бэ? Нэгдүгээрт. Энд ерөөсөө хариулт өгөхгүй юм.

Хоёрдугаарт, энэ Улсын Их Хурал чинь хоёр бүлэгтэй. Нэг нь манай Ардчилсан намын бүлэг. Ардчилсан намын бүлэг хуралдаад шийдвэрлэчихлээ. Энэ хуулийг дэмжих боломжгүй ээ гэж байгаа.

Тэгээд яах юм. Та нар ингээд хүчиндээд батлах юм уу? Өчнөөн яривал зөндөө л юм байгаа. Гишүүд ярьчих шиг боллоо. Тэр хуулийн бүрдэл хэсгийг хангах гээд. Одоо тэр оролцох ёстой намуудаас нь санал хүсэлтийг нь авах, хэлэлцүүлэг хийх энэ тэр гээд. Хэрэгжээд явж байгаа юмыг дундуур нь ингэж зогсоож яах гээд байгаа юм бэ? Хэрэгжээд л яваг л даа. Сайн сайхан хууль байна гээд л бүгд л яриад байх юм.

Тэгээд хэрэгжээд явахад нь юунд нь дургүйцээд байгаа юм.

Х.Булгантуяа: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ. Хууль мэдээж хууль тогтоомжийн тухай хуулийнхаа дагуу бүх процедураар дамжаад өргөн баригдаж байгаа шүү дээ.

Би бодохдоо Засгийн газар дээр Хууль зүйн яамны том дүгнэлтийн дагуу энэ хууль орж ирсэн гэж бодож байгаа. Танайх танайх гээд л яриад байх юм. Хууль зүйн яам маань яг үндсэндээ Ардчилсан намын сайдтай байж байгаа шүү дээ.

Тэгэхээр тэнд яг зөв өнцгөөс нь харсан болов уу л гэж итгэж байгаа. Угаасаа энэ Засгийн газрын босгыг даваад хууль өргөн баригдана гэдэг бүх процедураар батлагдаад орж ирж байгаа шүү дээ. Тэр тусмаа Хууль зүйн яамны визгүйгээр энэ хууль хэзээ ч өргөн баригддаггүй.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан. Б.Жаргалан гишүүн байхгүй байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн. Ж.Чинбүрэн гишүүн байхгүй байна. Гомбын Ганбаатар.

Г.Ганбаатар: Миний асуух гэж байгаа асуултыг түрүүн Б.Түвшин гишүүн асууж байгаа харагдана лээ. Гэхдээ яах вэ, саналаа хэлчихье ээ.

Улс орон даяар бид чинь төсвөө хэлэлцэж чадахгүй, Ерөнхийлөгчөөс хориг тавиулчхаад байж байгаа мөртлөө одоо ингээд Улс төрийн намын тухай хууль хэлэлцээд сууж байгаа нь нэг бодлын эмгэнэлтэй ч юм шиг.

Ер нь энэ хууль хэлэлцэх дараалал, хөрөнгө оруулалт, нэн тэргүүнд юу нь чухал вэ гэдгээ ерөөсөө л манай парламент үүнийг л барихгүй юм даа.

Тэгээд энэ 2023 оны тэр 7 сарын 07-нд энэ баталсан хуулиа дахин өөрчлөх болж байгаа нь, ялангуяа энэ хууль хэрэгжих хугацааг нь бүр 2027 оны 8 дугаар сарын 01 гээд оруулж ирж байгаа нь үнэхээрийн олны эгдүүлцлийг хүргэж байна шүү дээ.

Хууль зүйн яамаараа хянагдаад Засгийн газраас өргөн барьж байгаа болохоор Улсын Их Хурлаар хэлэлцэх л байлгүй.

Зүгээр хувь хүний бодол тэр 2027 оны 8 сарын 01 хүртэл энэ хугацаа бол инээдтэй шүү. Үүнийгээ эргэж бодолцоорой л гэдгийг хэлье. Миний асуултыг түрүүнд асуучихлаа л даа.

Х.Булгантуяа: Г.Ганбаатар гишүүн санал хэллээ. Тийм ээ. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн.

Д.Жаргалсайхан: Энэ хууль Ерөнхийлөгч өргөн барьж батлуулж, Монгол Улсад намуудын өнөөдрийн байгаа байдал болохгүй байна. Ард иргэдээс бас олон саналууд гарч байна.

Ер нь энэ нийгэмд болохгүй бүтэхгүй байгаа энэ авлига, хээл хахуультай холбоотой, энэ хүнд сурталтай холбоотой, тэгээд энэ эрх барьж байгаа энэ намуудтай холбоотой, энэ засаг барьж байгаа хамтарсан намуудтай холбоотой зөндөө асуудлууд байгаа юм.

Тэгээд энэ хуулиар бас хэрэгжээд эхэлчихсэн олон сайн талууд байгаа.

Гэтэл энэ хуулийг ингээд нэг зүйл, заалтыг нь хойшлуулаад тэр зүйл, заалт дээр ерөөсөө ойлгомжтой намуудыг хуралдах асуудал л байгаа юм.

Тэгээд хуралдуулахгүй байх энэ одоо яг ямар санаа агуулж байгаа юм. Тийм ээ. Яагаад энэ ганцхан заалтыг хойшлуулах болов оо. Ингээд хойшлуулаад бид хэлэлцээд энэ нэг юм өөрчлөгдөөд гарах байх. Ерөнхийлөгч хориг тавьчихвал яах вэ? Үүнийг бодож үзсэн үү? Энэ дээр ямар санал бодол байна вэ?

Мөн дээрээс нь бидний олон тулгамдсан ард иргэдэд шийдлээ хүлээж байгаа Улсын Их Хуралд бас орж ирж хэлэлцүүлэгдэж чадахгүй байгаа олон хуулиуд байгаа.

Гэтэл яг энэ хуулиудын ингээд очер дайраад ингэж орж ирж байгаа нь яг ямар учиртай юм? Энэ ийм ард түмэнд тулгамдчихсан чухал асуудал мөн үү? Ийм хоёр асуулт байна. Энэ дээр нэг хариулт авъя.

Х.Булгантуяа: Засгийн газрын хэрэг эрхлэхийн дарга Н.Учрал сайд.

Н.Учрал: Хууль тогтоомжийн хуулийн 27 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх журмаар дараах асуудлыг зохицуулна гээд 6 асуудлыг хуульчилсан байдаг.

27.1 дээр хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулж, шилжилтийн үе шатын бэлтгэлийг хангах, шинэ бүтэц, ажлыг гүйцэтгэх нөхцөл гээд.

Тэгэхээр яг өнөөдөр бид Улс төрийн намын хуулийн дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйл дээр буюу дагаж мөрдөх журмын хуулийн нөхцөл хангахад чиглэсэн үүрэгжүүлсэн буюу улс төрийн намуудыг тодорхой хугацаанд дүрмийн хуульд нийцүүлэе гэсэн үүрэгжүүлсэн заалтыг Дээд шүүхэд улс төрийн намууд дүрмээ шинэчилж бүртгүүлэх заалтыг зүгээр хугацааг нь дотор нь сунгаж байгаа болохоос биш Улс төрийн намын хууль 01 дүгээр сарын 01-нд хэрэгжиж байгаа шүү. Тэрийг бас ойлгох ёстой юм байгаа юм.

Дагаж мөрдөх журмын хуулиар өөрөө энэ нөхцөл хангуулахад чиглэсэн, бэлтгэл ажлыг хангуулахад чиглэсэн зохицуулалтуудыг л хийдэг. Үүнийг Хууль тогтоомжийн хуулиар зохицуулж өгсөн.

Тэгэхээр энэ хуулийг нэг мөр хэрэглэхийн тулд дагаж мөрдөх журмын хуулиар нэмэлт үүрэгжүүлсэн заалтуудыг хийсний үр дүнд хууль нэг мөр хэрэглэгдэнэ.

Тэгээд хуулийг нэг мөр хэрэглэе гэхээр нөгөө зохицуулах гээд байгаа энэ харилцааны оролцогч талууд буюу парламентад суудалтай болон суудалгүй намууд өөрсдөө энэ хугацаа ингээд богино байна энэ дээр нэг ийм дүрмээ

бүртгүүлэхэд тодорхой хугацаа өгөөч ээ гэдэг ийм хүсэлтийг тавьснаас болоод энэ асуудал хэрэгцээ шаардлагаас болж үүссэн.

Энэ утгаараа Хууль зүйн яамнаас боловсруулаад 3 улс төрийн намын дарга, парламентад суудалтай бусад эвсэл, намын дарга нарт энэ парламентад суудалгүй намууд санал хүсэлтээ илэрхийлээд, тэгээд үүнийг авч хэлэлцээд ингээд Засгийн газраар хэлэлцээд ингээд Их Хуралд өргөн мэдүүлж байгаа.

Тэгэхээр Их Хурал зөвхөн тэр бэлтгэл хангуулах, нөхцөл хангуулах үүрэгтэй. Дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйлийн бүртгүүлэх хугацаан дээр нь тодорхой боломж олгох уу эсэх асуудлыг Их Хурал шийдвэрлээд л явна гэсэн үг. Тэр хуулийнхаа хүрээнд л явна.

Тэгэхээр Их Хурал ажлын хэсгээ байгуулаад хугацааг нь магадгүй жил болгоно уу, жил хагас болгоно уу, тэрийг мэдээж улс төрийн намуудтай тэрийг нь оролцуулж байгаад ингээд шийдвэрлээд явах бүрэн эрх нь Их Хуралд хадгалагдаж байгаа.

Засгийн газар бол мэдээж хуулийнхаа хүрээнд хуулиа өргөн мэдүүлээд л Их Хурлаар хэлэлцүүлж явж байгаа гэсэн үг.

Тэгээд гишүүдийн хэлж байгаа саналуудыг манай энэ ажлын хэсэгт байгаа улс төрийн намууд, парламентад суудалгүй намууд хариуцлагатайгаар сонсох ёстой.

Цаг хугацаандаа ажлаа хийх ёстой. Институт болж бүрэлдэх ёстой. Тэгж байж цаашаа хаа хаанаа хариуцлагатай байна. Энэ улс төрийн намын шинэчлэлээ бид хамтдаа үргэлжлүүлэх ёстой л гэсэн ийм байр суурьтай байна.

Х.Булгантуяа: Д.Жаргалсайхан гишүүн тодруулъя.

Д.Жаргалсайхан: Хариулт авч чаддаггүй дээ. Ерөнхийлөгч хориг тавих боломж байгаа юу, тавих уу? Энэ дээр ер нь ямар санаа бодол байна вэ гэсэн.

Дараагийн асуулт энэ олон асуудлууд байгаа. Яагаад ингээд очер дайраад энэ нэг ийм чухал асуудал мөн үү? Ард түмэнд тулгамдаж байгаа асуудал мөн үү?

Тэгээд яг өөрийн чинь яриан дээрээс гарч байна шүү дээ. Энэ намыг өнөөдөр шинэчлэх, нээлттэй байх, бас юу гэдэг юм бидний ард түмэнд байгаа тулгамдаж байгаа олон асуудлууд дээр улс төрийн намын бохирдлыг бүгд ярьж байгаа шүү дээ.

Тэгээд үүнтэй холбоотой энэ Ерөнхийлөгч шинэчлэх ийм том хуулийн төсөл хэрэгжээд эхэлж байтал яагаад дундаас нь хугацааг нь хойшлуулж байгаа юм?

Тэгээд чухал шаардлагатай юм уу гэж асуусан шүү дээ. Энэ хоёр дээр тодорхой хариулт өгөөч.

Х.Булгантуяа: Н.Учрал сайд.

Н.Учрал: Мэдээж Ерөнхийлөгч хориг тавих эсэх асуудал дээр би тайлбар хийх тийм субъект биш л дээ. Тэр Ерөнхийлөгчийн онцгой бүрэн эрхийн асуудал.

Засгийн газар өргөн мэдүүлсэн хууль санаачлагчийн хувиар хэлэлцэх эсэхээ дэмжээд Их Хурал ажлын хэсгээ байгуулаад, тэгээд таны зарчмын саналуудыг, мэдээж Та Байнгын хороон дээр гаргаад дэвшүүлээд, ингээд ажлын хэсэгт нь саналаа тусгаад явах Их Хурлын гишүүний эрх нь байгаа учраас тэр хэлэлцүүлгийн явцад Төрийн байгуулалтын байнгын хороо үүнийг анхаарах байх гэж бодож байна.

Хэрэгцээ шаардлагын хувьд яалт ч үгүй нөгөө оролцогч талууд, ашиг сонирхол нь хөндөгдөөд байгаа талууд өөрсдөө л ийм шаардлага тавиад байгаа юм л даа.

Тийм учраас анхаарахгүй байж болоогүй. Тийм учраас л ингээд нээлттэй хэлэлцээд шийдвэрлээд явъя. Их Хурал эцсийнхээ шийдвэрийг гаргаад явах байх гэж ингэж бодож байгаа.

Тэгээд ер нь улс төрийн намууд хариуцлагагүй байгаа гэдэг дээр бүгд л санал нэгдэж байна шүү дээ.

Х.Булгантуяа: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ нэмэлт хариулт өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Очер дайраад гэхийн хувьд энэ юу л даа. Бид нар чинь өргөн барьсан хуулиуд чинь чуулган нэг 4 жилийн хугацаанд өргөн барьсан бүх хуулиуд хэрвээ хэлэлцэгдэж амжаагүй бол энэ бүх хуулиуд буцчихаж байгаа юм.

Тийм болохоор одоо дахиад энэ шинэ чуулган эхэлснээс хойш 2024 оноос эхлээд дахин хуулиуд өргөн баригдаад орж ирж байгаа юм.

Тэгээд энэ хуулийнхаа процедураараа явж байгаа. Буцаад өргөн баригдаад процедураараа хэлэлцэгдээд эхэлж байгаа байхгүй юу даа. Тийм болохоор нэг их айхтар олон хуулиуд овоорчхоод, тэгээд тэрний ар дээр очер дайраад орж ирж байгаа юм байхгүй шүү.

Яг хуулиуд яг л анхных дахин өргөгдөөд процедурууд яваад орж ирж байгаа хууль.

Хоёрдугаарт, хууль дээрээ 7 сарын 01-нээс 6 сарын хугацаанд гээд тэгэхээр энэ чинь өөрөө нэг сар луу орчхоод байгаа юм л даа.

Тийм болохоор энэ намууд хүсэлтээ гаргаж орж ирээд.../минут дуусав/

Х.Булгантуяа: Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо үг хэлэхээр нийтдээ 6 гишүүний нэр ирсэн байна.

Үг хэлэх гишүүдийн хувьд индэр дээрээс үг хэлэхээр байгаа.

Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намаас Д.Энхтүвшин. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн. Алга байна.

Дараагийнх нь, Ц.Идэрбат гишүүн. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн. 1 номерын индэр дээрээс.

Ц.Идэрбат: Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн барьсан энэ Улс төрийн намын тухай хууль бол сая гишүүд хэлж байна. 20, 30 жил яригдсан ийм л асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс энэ улс төрийн намуудыг шилэн болгох, тунгалаг болгох, зарчим, зорилтдоо чиглэдэг байх, ёс зүйтэй байх гээд олон зүйлүүдийг тусгасан ийм том хуулийг өнгөрсөн парламентаар баталсан.

Тэгээд өнөөдөр энэ хуулийн хэрэгжилт хэрэгжээд явж байгаа. Дагаж мөрдөх хуулийн ганц нэг заалт хойшлогдох ийм л асуудал яригдаж байна.

Бид Үндсэн хуулийн үзэл баримтлалаараа ч тэр, энэ олон намын системийг бий болгох энэ том эрх зүйн өөрчлөлтөд шилжээд олон жил болж байгаа.

Тийм учраас олон намын энэ системээ цааш нь төгөлдөржүүлэхэд өнөөдрийн өөрчлөлтийг би хийх нь зүйтэй гэж үзэж байгаа. Яагаад гэвэл зарим нэг намууд, зарим гишүүдийн хэлж байгаатай адилхан хариуцлагагүй хандаж байгаа ийм зүйлүүд байна.

Гэхдээ энэ намууд Монголын улс төрд гишүүдээ төлөөлөөд, улс төрийн институц нь улам хөгжих бололцоог бид хуулиараа бүрдүүлж өгөх ёстой.

Үндсэн хуульдаа бид нэлээдгүй томоохон өөрчлөлт хийсэн. Ялангуяа Их Хурлын гишүүдийг 126 болгосон том өөрчлөлт.

Мөн дээрээс нь парламентад олон нам орж ирэх бололцоог бид хууль эрх зүйн хувьд хангаж өгсөн юм. Олон намын системтэй гэж ярьж байгаа боловч хоёр нам бараг ээлжлээд шахуу явж байсан энэ тогтолцоог өөрчлөхийн тулд 126 гишүүнтэй энэ парламент бүрдэж, анхны парламент 5 намаас бүрдсэн.

Өнөөдөр парламент дээр хэлэлцүүлэгдэж байгаа асуудлуудыг олон талаас нь харж ярьж шүүмжилж байгаа нь бас энэ 5 нам бүрдсэний, энэ олон нам бүрдсэний бас нэг том ач холбогдол нь ил гарч байгаа гэж миний хувьд дүгнэж байгаа.

Тийм учраас Улс төрийн намын тухай хууль дагаж мөрдөх хуулийн энэ асуудлыг өнөөдөр хэлэлцэх эсэхийг нь хэлэлцээд ажлын хэсэг гараад харин хугацаа нь ямар байх вэ гэдэг тал дээр бас ярилцах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа.

Миний энд гарч ирж байгаа гол нэг зүйл бол ер нь ингээд Монголын улс төрийг цэвэр болгох, тунгалаг болгох энэ асуудал улс төрийн намаасаа эхлээд явж байна. Одоо улс төрийн сонгуулийг мөнгөнөөс хараат бус байлгах, мөнгөний нөлөөллийг бууруулах тал дээр энэ Их Хурал манлайлалтай ажиллаасай гэж бодож байгаа.

Өнгөрсөн парламентын үед Засгийн газарт сонгуулийн тухай хуульд мөнгөний нөлөөллийг бууруулах талаар санал авах саналаа илэрхийлчихсэн ингээд явж байгаа.

Тэгэхээр би энэ удаагийн парламентаас энэ Улс төрийн намын хууль одоо ингээд хэрэгжээд явна. Дээрээс нь нэмээд улс төрийн сонгуулийг бид мөнгөнөөс хараат бус болгох энэ эрх зүйн том өөрчлөлтийг зайлшгүй хийх ёстой.

Иргэд олон нийт 5 саяын цалинтай Их Хурлын гишүүд Улсын Их Хуралд сонгогдохын тулд 500, 600 сая, тэрбум төгрөг зарцуулж байгааг үнэндээ ойлгохгүй байгаа гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Тоон утгаараа энэ бол асар их зөрүүтэй ийм зүйл.

Тэгэхээр ер нь энэ сонгуульд ийм их хэмжээний мөнгө зарцуулдаг биш. Энэ хэмжээний мөнгө зарцуулахгүй ч улс орныхоо төлөө ажиллах тэр чин зүтгэлтэй хүмүүсийг энэ парламентад оруулж ирэх тэр том эрх зүйн өөрчлөлтийг би энэ удаагийн парламент хийгээсэй.

Тийм учраас энэ өөрчлөлтөө хийхийн тулд энэ парламент бас.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Агваанлуvsангийн Ундраа гишүүн. 1 номерын микрофон.

А.Ундраа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая.

Улс төрийн намын шинэчлэл бол Монголын парламентын ардчиллын хамгийн гол баталгаануудын нэг.

Тэгэхээр улс төрийн намуудын дотоод ардчилал хөгжих, улс төрийн нам бодлогын институц болж төлөвших, олон нийтийн сонголтын төлөө сонголт шиг сонголт байх боломжийг улс төрийн намууд бий болгох ёстой.

Тэр үүднээсээ энэ Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилт, дагалдаж гарч байгаа журмын хэрэгжилтийг нэн даруй хэрэгжиж эхлэх ёстой гэдэг байр суурьтай байна.

Манай Үндэсний эвслийн зүгээс Монголын Ногоон нам, бас Монголын Үндсэн Ардчилсан намуудын хувьд Улсын дээд шүүхэд дүрмийн өөрчлөлтүүдээ хүргүүлсэн.

Мөн түүнчлэн бодлогын институц болж төлөвших, тэр үүднээсээ гишүүдийнхээ санал санаачилгыг байнга тусгаж байх үүднээс Үндэсний эвсэл гэсэн апп хөгжүүлж гишүүд дээрээ өргөн хэмжээнд хэрэглэж байгаа.

Бас энэ Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжих журмын хэрэгжих хугацааг хойшлуулахын бас нэг цаад нюанс нь түрүүн олон гишүүд хэлж байна л даа. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн сонгуульд оролцох тэр тэгш эрхийг хангах асуудлыг тодорхой хэмжээнд хойшлуулснаараа хойшлуулж байгаа юм биш үү гэдэг.

Бид 126 гишүүнтэй парламент анх бүрэлдэж үйл ажиллагаагаа явуулаад 4 сар орчим болж байна. Энэ парламент нийтдээ 32 эмэгтэй гишүүнтэй гэдгээрээ Монголын парламентын түүхэнд хамгийн олон эмэгтэй гишүүдтэй парламент байгаа.

Тэгэхээр энэ 32 эмэгтэйчүүд нэр дэвшиж сонгогдох боломжийг Сонгуулийн тухай хуулиар, тэр дундаа хувь тэнцүүлсэн тогтолцоог оруулж ирснээрээ намууд эрэгтэй, эмэгтэй сөөлжүүлэн нэр дэвшүүлж энэ олон эмэгтэйчүүд дэвшиж сонгогдох боломж бүрдсэн.

Энэ бол Монгол Улс бид бүгд найрамдах засаглалаа сонгож Үндсэн хуулиа баталсан 100 жилийн ойг хэдхэн өдрийн өмнө тэмдэглэн өнгөрүүллээ.

Тэгээд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн сонгох сонгогдох эрхийг хангаад 100 жил ж байгаа гэж бахархан ярьж байгаа боловчиг энэ 100 жил дотор үнэхээр тэр тэгш эрх хангагдсан уу, үгүй юу гэдгийн ямар удаан явж ирсэн бэ гэдгийн илрэл нь энэ 32 гэдэг тоо. Энэ 25 хувь хамгийн өндөр гэж тооцогдож байгаа юм.

Тэгэхээр энэ тэгш сонгогдох эрх нь бүрэн баталгаажаагүй байна гэдгийг дөнгөж дөрөвний нэгээр бүрэлдэж байгаа энэ бүрэлдэхүүн.

Тэгээд үүнийгээ маш өндөр амжилт мэтээр бид өөрсдөдөө алга ташин баяр хүргэж байгаа энэ явдал маань харуулж байна. Хэдийгээр энэ харьцангуй амжилт мөн боловч энэ абсолют амжилт биш гэдгийг саяын тэгш эрх хангагдаагүй энэ тоо харуулж байна.

Тэгэхээр намуудын хувьд дүрэмдээ өөрчлөлт оруулаад аль нэг хүйс нь 40 хувиас доошгүй байх тэр нөхцөлийг хангах бүрэн бололцоо байгаа. Улс төрийн намуудын гишүүнчлэлийн бүрэлдэхүүнийг харах юм бол ихэнхдээ эмэгтэйчүүд олонх байдаг.

Тэгээд яагаад ямар нүүрээрээ тэр олон эмэгтэй намынхаа эгэл жирийн гишүүдийн өмнө бид энэ жендэрийн тэгш тэгш төлөөллийг хангах бололцоогүй гэж яриад сууж байгаа юм бэ. Зарим намын удирдлагууд. Үүнийг харахад гайхаж байна.

Нөгөө талдаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Солонгосын КОЙКА байгууллагын дэмжлэгтэйгээр сонгуулийн хууль өөрчлөгдөж энэ бололцоо боломж нээгдсэн.

Гэхдээ тойргоос сонгогдсон эмэгтэй гишүүдэд байдал маш хүнд байсан шалтгаан нь гол нь нь намын санхүүжилттэй, сонгуулийн зардал маш өндөр байгаатай холбоотой.

Тэгээд намын санхүүжилт ил тод бус байх, сонгуулийн зардал хэдий чинээ өндөр байна төдий чинээ дараа нь засаглах процесс өөрөө авлигад автагдах эрсдэл төдий чинээ өндөр байгаа юм.

Ийм учраас Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг аль болох хойшлуулахгүйгээр нэн даруй хэрэгжүүлж, намууд институцийн хувьд бэхжих, ил тод байх зарчмын шаардлагыг бас Үндэсний эвслийн зүгээс тавьж байгаа юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат гишүүн. 2 номерын микрофон.

Д.Ганбат: Эх нь булингартай адаг нь булингартай гэгчээр ерөөсөө энэ намууд нь өөрөө ингээд авлигажаад болохгүй болохоор чинь л энэ улс орон чинь авлигад идэгдээд болохгүй байна гэсэн иргэд олон нийтийн шүүмж л явж байгаа шүү дээ.

Тэгээд би хуулийг түрүүн үг, үсгээр нь танилцууллаа хэрэгжээд явж байгаа. Хуультай холбогдуулаад ямар нэгэн байдлаар хэн нэгэн ямар ч хуулийг өргөн барихгүй ээ гэсэн ийм тов тодорхой заалт байна лээ шүү дээ.

Тэгээд хуулийг хэрэгжүүлэхдээ хамгийн түрүүнд манлайлж үзүүлж байх ёстой Засгийн газар маань ингэж байгаа нь туйлын харамсалтай байна

Тэгээд үүнийг хэлэлцээд байж байгаа энэ Улсын Их Хурал ч гэсэн үнэхээр тийм сонин байдалд орж байна шүү дээ. Үүнийгээ боливол яасан юм бэ? Хуулиа татаад авчих л даа. Эсвэл хэлэлцэхээ боль л доо. Үгүй ээ энэ Засгийн газар чинь хэдэн удаа бүдрэх гэсэн юм бэ? Нэг бүдрэхээрээ 7 бүдэрнэ гэгчээр анх л энэ Монгол Ардын нам чинь олонх болсон юм байгаа биз дээ. Эхлээд олонх болчихоод Үндсэн хуулийнхаа дагуу өөрсдөө засаг байгуулаад явах байсан шүү дээ.

Тэгээд чадахгүй бол бусад намын оролцоог авах ёстой байсан. Үүнийгээ ч хийсэнгүй.

Сая Монгол Улсын төсвийг яаж хэлэлцэв. Анх удаагаа. 126 гишүүнтэй боллоо. Монгол Улс маш сайхан болох нь гэсэн ийм сурталчилгааг байнга явуулсан.

Тэгээд иргэдийн хүлээлт маш өндөр байсан. Өнөөдөр гадаа ямар байна. Хөдөө орон нутагт нөхцөл байдал маш хүнд байна шүү дээ. Иргэдийн амьдрал хүнд байна. Энэ Улсын Их Хурал Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа 5 сар болчихлоо. Энэ 48 сарынхаа бараг 12 хувийг нь авчихлаа.

Тэгэхэд хийж гийгүүлсэн юм юу байна. Одоо 100 хоног болчихоод аль ч Засгийн газар ардчилсан улс оронд ямар зүйл хийсэн, яах гэж байгаа, ийм байна гэдгээ танилцуулдаг шүү дээ. Тийм юм алга.

Монгол Улсын төсвийг яаж хэлцэв бид. Тодотгол хийнэ гэж хуулийг бас яасан ч юм. Төсөв байхгүй байж байна шүү дээ.

Ийм нөхцөл байдалтай ийм байхад больсон нь дээр байх нөхдүүд ээ. Иргэд энэ Засгийн газрыг чинь огцруулах гээд байгаа хүн нэг ч алга. Энэ намын дарга нар нь намын гишүүд дээрээ очиг л доо. Энэ Засгийн газрыг байгуулсан парламентад суудалтай намууд гээд цээжээ дэлдээд байдаг.

Иргэдийн санал өгсөн шүү дээ. Очоод энэ намаа, энэ мөрийн хөтөлбөрөө, дүрмээ, зохион байгуулалтаа хуульд нь нийцүүл л дээ. Хэчнээн удаа хойшлуулах гэсэн юм бэ энэ хугацааг. Ингэж болохгүй байх гэсэн ийм бодолтой байна. Бид чинь эргээд очоод уулздаг ард түмэнтэй. Ард түмнийхээ хэлсэн ярьсан өгсөн санал бодлогыг хэрэгжүүлж энэ улс орны амьдралыг өөд нь татах ёстой.

Тэгээд орох орохгүй юманд орох юм энэ Монгол Ардын нам. Энэ Засгийн газар нь. Зүв зүгээр хэрэгжээд явж байгаа хуулийг л өөрсдийнхөө өмнөх ажлаа хийхийнхээ оронд үүнийг хойшлуулъя гээд л байдаг.

Одоо төсөв ч алга. Улс орон хүнд байна шүү дээ. Гадаа маш хүйтэн өвөл ирчихсэн байна. Эрчим хүчний реформ хийнэ гэж ярилаа. Үнэ л нэмлээ шүү дээ. Өөр юм алга байна шүү дээ. Энэ улс орон одоо хөлдөх юм уу. Энэ хот чинь яах

юм. Хотын агаарыг хар л даа. Ийм агаараар амьсгалсан улсууд ийм байх ёстой юм уу. Үүнийгээ эртхэн татаж аваад больсон нь дээр байх.

Яг ийм зүйлийг би Монгол Улсын төсвийг хэлэлцэж байх үед нь.../минут дуусав/

Х.Булгантуяа: Д.Ганбат гишүүн үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан. Л.Мөнхбаясгалан гишүүн байхгүй байна.

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэллээ. Санал хураалтыг Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 10.12-ын дагуу маргааш явуулъя.

Ингээд дараагийн асуудалдаа орё.

**Гурав.Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг
соёрхон батлах тухай хуулийн төсөл**
/Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн,
соёрхон батлах/

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан танилцуулна.

Ц.Туваан сайдыг индэрт урьж байна. Ц.Туваан сайд сая энд явж байсан. Хаачив? Цэвэгдоржийн Туваан сайдыг индэрт урьж байна.

Ц.Туваан: Улсын Их Хурлын дэд дарга, Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал 2009 онд Цөмийн энергийн тухай хууль болон Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг баталж, Улсын Их Хурлаас 2010 онд батлан гаргасан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.4.4-д цөмийн эрчим хүчний салбарыг үндэсний ашиг сонирхол, энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлнэ. Цөмийн циклийг хөгжүүлж, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлт, баяжуулалт, эрчим хүчний үйлдвэрлэлийг бий

болгож бэхжүүлнэ. 3.5.4.4-д түүхий нүүрсийг дулааны аргаар гүн боловсруулах, хийжүүлэх, шингэрүүлэх замаар эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, ахуйн хэрэглээний цэвэр түлш үйлдвэрлэх аливаа үйлдвэрлэлийн технологид хэмнэлттэй дэвшилтэт байх шаардлагыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр дамжуулан тавина. Нар салхины сэргээгдэх эрчим хүч ашиглахыг нэмэгдүүлж, цөмийн эрчим хүчийг ашиглана гэж тус тус заасан байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Алсын хараа-2050”-д нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүчний үйлдвэрлэл зэрэг стратегийн ач холбогдол бүхий эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэх зорилт тусгагдаж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.7-д ураны нөөцийг түшиглэн атомын цахилгаан станц барих бодлого хэрэгжүүлж, суурь судалгааг хийнэ гэж тусгасан бөгөөд Олон улсын атомын энергийн агентлагаас цөмийн эрчим хүч барьж байгуулахаар төлөвлөж буй 27 улсын жагсаалтад Монгол Улсыг оруулсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 6 сарын 19-ний өдрийн Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай 60 дугаар тогтоолоор Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт болон Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан байна.

Тус Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор уг конвенцод нэгдэн орох асуудлыг Засгийн газрын 2023 оны 8 сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон.

Түүнчлэн Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 11 сарын 21-ний өдрийн хуралдаанаар уг конвенцыг дэмжсэн болно.

Цөмийн аюулгүй ажиллагааны 1994 оны конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар 2024 оны 10 сарын 13-ны өдөр баталсан байна.

Засгийн газрын 2024 оны 11 сарын 13-ны өдрийн хуралдаанаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд 11 сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Монгол Улс нь цөмийн байгууламжгүй хэдий ч цөмийн түлшний циклийг бүхэлд нь хэрэгжүүлдэг цөмийн зэвсэгтэй хоёр их гүрний дунд оршиж байдаг газар зүйн онцлогтой улс.

Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын цөмийн байгууламжийн аюулгүй байдал нь тухайн улсын хяналтын байгууллагын чанд хяналтад байдаг хэдий ч болзошгүй ослын үед манай улсад хил дамнасан цацраг идэвхт бохирдол үүсэх эрсдэл байх боломжтой.

Шинээр барьж буй болон үйл ажиллагаа явуулж буй цөмийн байгууламж нь түүний ойр орчимд байх хөрш зэргэлдээ улсын нутаг дэвсгэрт нөлөөлж болзошгүй учраас тухайн талтай зөвлөлдөх хүсэлт гаргасан тохиолдолд цөмийн байгууламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авах замаар өөрийн нутаг дэвсгэр дээр үүсэж болзошгүй гаднын нөлөөллийг тооцох, аюулгүй ажиллагааны үнэлгээг хийх хил дамнасан ослын үед авах арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулах, хариу арга хэмжээ авах нөхцөл бүрдэх юм.

Ингэснээр өөрийн орны хүн ам, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, аюулгүй байдлыг хангах боломж бүрдэнэ.

Цөмийн байгууламжтай шууд холбоотой үйл ажиллагаа эрхэлж буй бүх байгууллага, цөмийн аюулгүй ажиллагааг тэргүүн ээлжид хангах, бодлого боловсруулж, мөрдөх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

Цөмийн байгууламжийн үйл ажиллагааны бүхий л үе шат нь тухайн байгууламжид ажиллагсад болон хүн амд үзүүлэх цацрагийн шарлагын хэмжээг байж болох хамгийн бага түвшинд байлгах нөхцөлийг хангах, цөмийн аюулгүй байгууламжийн биет байдал, түүний үйл ажиллагаа нь зураг төсөл, аюулгүй ажиллагааны холбогдох үндэсний шаардлагууд болон үйл ажиллагааны нөхцөл, хориг, хязгаарлалтад нийцэж буй эсэхийг судалгаа шинжилгээ явуулах, туршилт шалгалт хийх замаар тогтоож баталгаажуулах, цацрагийн осолд өртөх магадлалтай байвал цөмийн байгууламжийн хөрш зэргэлдээ орших өөрийн хүн ам болон эрх бүхий байгууллагуудын ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, хариу арга хэмжээний талаар холбогдох мэдээллээр хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авах шаардлагатай байдаг.

Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглахад цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн ам, нийгэм, хүрээлэн буй орчныг хамгаалах хяналтын тогтолцоо бий болгох, шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагааны хүрээнд техникийн дэмжлэг туслалцаа авах боломжтой болно.

Уг конвенцод нэгдэн орсноор Монгол Улс санхүүгийн ямар нэгэн үүрэг хүлээхгүй.

Монгол Улсад мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн зүйл, заалт байхгүй болно.

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенцыг Олон улсын атомын энергийн агентлагийн гишүүн орнуудын санаачилгаар 1994 онд баталж, 1996 оны 10 дугаар сарын 24-нд хүчин төгөлдөр болсноос хойш одоогийн байдлаар 96 улс нэгдэн орсон байна.

Иймд Цөмийн аюулгүй ажиллагааны 1994 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай танилцуулна.

Н.Алтаншагай гишүүнийг индэрт урья.

Н.Алтаншагай: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Монгол Улс өмнө нь ямар ямар конвенцод нэгдэж байсан, нэгдэн орсон боловч үүргээ биелүүлээгүй тохиолдол байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд хуулийн төслийн талаарх үнэн зөв мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх, иргэдийг төөрөгдүүлэхгүй байхад анхаарах талаар үг хэлсэн болно.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжин, соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Гүнчинсүрэнгийн Намжинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга, Жамбалдоржийн Соёлмаа Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Балдоржийн Баатарцогт Цөмийн энергийн комиссын ажлын албаны Тамгын газрын дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Нямдолгорын Од-Эрдэнэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын ахлах шинжээч, Гомбосүрэнгийн Гэрэлмаа Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Эрдэнэболдын Цэрэнчимэг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. /алх цохив/

А.Ундраа гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ.

Б.Бат-Эрдэнэ: Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл соёрхон батлах.

Энэ цөмийн аюулгүй байдлыг хангах байгууллагуудын чадавх яг манай улсад хангалттай байгаа юу? Мэргэшсэн хүний нөөцтэй холбоотойгоор яг энэ хүний нөөц манай улсад бас байгаа юу? Энэ асуултуудыг асуумаар байна.

Дээрээс нь энэ цөмийн аюулгүй байдалтай холбоотой асуудалд иргэдийн мэдээлэл авах эрхийг хэрхэн хангаж байгаа вэ? Бид цөмийн энерги, цөмийн аюулгүй байдал, уран гээд л ингээд л нэг юм ярихаар иргэдийн хувьд маш олон төөрөгдсөн байдал руу нэг талдаа ордог. Энэ мэдээллийн ил тод байдалтай холбоотой болов уу гэж ойлгож байгаа.

Энэ мэдээллүүдийг бид ялангуяа иргэдийн мэдээлэл авах эрхийг хэрхэн хангаж байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Конвенц яах вэ ингээд соёрхон батлагдах байх. Конвенцын хэрэгжилтийг хангах, энэ хянах механизмыг яг ямар байдалтай байх юм? Механизм нь өөрөө. Энэ дээр би хариулт авмаар байна.

Конвенцын хэрэгжилтийг хангахад шаардагдах төсөв, санхүүгийн хувьд эх үүсвэр нь яаж хэрхэн шийдвэрлэгдэх юм бэ гэсэн ийм асуултуудыг асууя.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн. Ц.Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Бид бүхэн өнөөдөр Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Мөн Франц Улстай хийх Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээний асуудлыг бас ярьж байгаа энэ цаг үед бид бас Улсын Их Хурлаар ороод шийдвэр нь гарчихсан, Засгийн газраар орчихсон энэ конвенцуудыг Их Хурлаар соёрхон батлуулахаар оруулж байгаа.

Энэ дотор Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, Бага хэмжээний цөмийн материалыг шинэчилсэн протокол гэсэн энэ конвенцуудыг оруулж ирж байгаа.

Тэгэхээр Монгол Улс яг одоогийн байдлаар 10 орчим энэ цөмийн энергитэй холбоотой олон улсын атомын энергийн конвенцуудад нэгдэн орсон байгаа.

Тэгээд энэ дээр нэмээд бид бүхэн энэ 3 конвенцыг оруулж ирж байгаа. Мөн нэмэлт материалыг бэлдээд бас дахиж оруулж ирэх конвенцууд бас байгаа гэдгийг хэлье.

Тэгээд манай улсын хувьд энэ Цөмийн энергийн комисс үйл ажиллагаа явуулдаг. Комиссын даргаар нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд. Өмнө нь Боловсрол шинжлэх ухааны сайд байсан.

Тэгээд Цөмийн энергийн комисс дэргэдээ ажлын албатай. Ажлын алба маань 33 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг.

Тэгээд мөн Монатом гээд төрийн өмчит компаний, Эрдэнэс Монгол нэгдлийн доор ажилладаг.

Тэгэхээр бид бас яах вэ, ер нь чадавхын хувьд Олон улсын атомын энергийн агентлагтайгаа маш нягт хамтарч ажиллаж, өөрсдийн байгаа боловсон хүчин, төсөв санхүүгийн хүрээнд үйл ажиллагаагаа боломжийн явуулж байгаа гэж үздэг.

Цөмийн энергийн агентлаг өмнө нь үйл ажиллагаа явуулж байгаад бас татан буугдаад 2014 онд байх. Татан буугдаад ажлын албатайгаар ажиллаж байгаа.

Бас энэ цөмийн энергитэй холбоотой асуудал яригдаж байгаа үед энэ талын байгууллагаа өргөтгөх боломж байвал бас өргөтгөөд ийм агентлагийн түвшинд үйл ажиллагаа явуулбал зүгээр байгаа.

Боловсон хүчний хувьд бид харьцангуй өмнө нь нэлээн бэлтгэгдсэн боловсон хүчнүүд байна.

Дээрээс нь Олон улсын атомын энергийн агентлаг, мөн Оросын Холбооны Улсын Дубнад гэх мэтчилэн мэргэжилтнүүдээ бэлддэг.

Мөн цөмийн энергийн талаар Монгол Улсын Их Сургуульд одоогийн байдлаар 30-аад хүүхэд сураад төгсөөд явж байгаа. Боловсон хүчний чадварын хувьд бас бэлтгэгдсэн.

Тэгэхдээ л яг өнөөдрийн байдлаар боловсон хүчний маань асуудал бусад бүх салбаруудын адилаар нэлээн хүнд байдалтай, хүндрэлтэй нөхцөл үүсэж ирж байгаа гэдгийг хэлье.

Иргэдэд өгөх мэдээлэл гэдэг бол маш чухал асуудал.

Тэгээд энэ дээр нэг л асуудал байгаа нь мэдээллийн эх үүсвэр, мэдээлэл өгөх арга хэрэгсэл маань нэлээн үнэ цэнтэй болчихсон учраас.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ц.Туваан сайдад нэмэлт 1 минут өгье.

Ц.Туваан: Тэгэхээр бид энэ дээр төсөв, санхүүгийн нэлээн асуудлууд байдаг.

Тэгэхдээ одоо энэ хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой асуудлууд сөхөгдөөд явж байгаа яг энэ иргэд анхаарлаа хандуулчихсан байгаа үед нь мэдээллийг өгч иргэдээ мэдлэгжүүлж авахгүй бол энэ төрлийн үйл ажиллагаанууд явахад нэлээн хүндрэлтэй зүйлүүд байгаа.

Энэ дээр бид шат шатдаа анхаарч ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Конвенцын хэрэгжилтийг бид хангуулаад явна. Цөмийн энергийн комиссын ажлын албаараа дамжуулаад салбарын яам хамтраад энэ конвенцуудынхаа хэрэгжилтийг бид хангуулаад явна.

Энэ өнөөдрийн орж ирж байгаа 3 конвенцын хувьд бид ямар нэгэн санхүүгийн нэмэлт эх үүсвэр шаардахгүй. Яг энэ Олон улсын атомын энергийн агентлагтайгаа хамтраад конвенцуудынхаа хэрэгжилтийг мэргэжилтэй боловсон хүчнийхээ хүрээнд шийдээд явах боломжтой байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Агваанлуvsангийн Ундраа.

А.Ундраа: Энэ Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл орж ирж Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор дэмжигдсэн байна.

Сая Ц.Туваан сайдын хэлсэн үгэнд гарч байгаа энэ цөмийн энергийн комиссыг ер нь Цөмийн энергийн газар ингээд агентлаг болгож өргөжүүлж ажиллах ёстой гэдэг дээр дэмжиж байна. Энэ зарчмын байр суурийг дэмжиж ирсэн.

Ер нь бий болгочихсон юмыг хумьж цөөлөх амархан. Дараа нь эргээгээд бий болгоход, ялангуяа энэ шинжлэх ухааны чиглэлийн мэргэжлийн хүмүүсийг бэлдэхэд асар их олон жилийн цаг хугацаа, хүч хөдөлмөр ордог учраас мэргэжлийн хүмүүсээ алдах аюултай.

Тэгэхээр Цөмийн энергийн газар гээд овоо явж байсан ажлыг ингээд хумьсан нь их туйлын буруу шийдвэр байсан.

Өнөөдрийн асуулт бол Цөмийн энергийн комиссоос Г.Гэрэлмаа даргаас, хоёрдугаар асуултыг Гадаад харилцааны яам газрын даргын үүрэг гүйцэтгэгч Ж.Соёлмааг даргаас асууя.

Эхний асуулт бол Цөмийн энергийн комиссын зүгээс энэ мэргэжлийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, нөөц бололцоог нь сайжруулах ажлууд тодорхой хэмжээнд хийгдэж байгаа.

Гэхдээ одоо бидний хувьд мэдээж хоёр том цөмийн зэвсэгтэй гүрний дунд байрладаг. Энхийн зорилгоор ашиглаж байгаа цөмийн байгууламжууд ч гэсэн маш олон тооны цөмийн байгууламжууд манай улсын хилийн зурваст ойрхон байрладаг.

Өмнө нь хүйтэн дайны үед цөмийн зэвсэг туршиж байсан. Одоо Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан Казакстаны нутаг дээрх Семипалатинск, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын тухайн үеийн газрын дээрх туршилтууд хийж байсан Лоб нуурын цөмийн туршилтын талбай гээд. Эдгээрээс хий салхиар дамжиж болон агаар мандлаар дамжиж ирсэн цацрагийн хордлого гээд энэ асуудлуудын үр дагавар олон жилийн туршид явж ирсэн.

Үүнээс ямар сургамж авах вэ гэхээр бид эрсдэлтэй бүс нутагт байрладаг гэж өөрсдийгөө тооцох ёстой.

Тийм учраас цөмийн аюулгүй байдал, эндээс урьдчилан сэргийлэх, ямар нэгэн юм боллоо гэхэд авах арга хэмжээний талаар маш их чадавхтай байх шаардлагатай байгаа юм.

Энэ дээр энэ сургалтуудын үр дүн хэр байна? Одоо юу шаардлагатай байна? Мэргэжлийн боловсон хүчний нөөц бололцоо ямар байна гэдэг талаар Г.Гэрэлмаагаас асууя.

Хоёрдугаар асуулт, Гадаад харилцааны яам.

Манай Монгол Улсын гадаад бодлогын хувьд цөмийн зэвсэггүй бүсийн статус манай гадаад бодлогын маш чухал нэг хэсэг. Бас батлан хамгаалах цагаан номд ч гэсэн тусгасан байгаа. Цөмийн зэвсэггүй бүсийн статусыг бид санаачилж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөр батлуулахын тулд дипломатуудын олон жилийн уйгагүй хөдөлмөрийн үр дүнд энэ бол НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөр батлагдсан байгаа.

Тэгэхээр бид энэ манлайллаа үргэлжлүүлэн авч явахад одоо энэ хэрэгжиж эхлэх гэж байгаа, бас нэгдэн орж соёрхон баталж байгаа энэ конвенцуудын үр нөлөөг юу гэж харж байна?

Тэгэхээр энэ дээр бас олон улсын тавцанд манайх өөрийн зүгээс үзүүлж байгаа манлайлал юм уу, үүнийгээ нэмэгдүүлэх чиглэлээр Гадаад харилцааны яам ямар нэгэн ажил хийж байна уу? Бэлтгэл хангаж байна уу? Энэ талаар тодруулж асуумаар байна.

Х.Булгантуяа: Шууд Г.Гэрэлмаа ахлах мэргэжилтнээс хариулаад явчих уу? Тэгье. Гомбосүрэнгийн Гэрэлмаа Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын ахлах мэргэжилтэн.

Яг нэрийг нь зааж байгаад асуусан учраас. Микрофон нь асчихсан байна шүү. Урд талын чинь микрофон асчихсан байна. Тийм.

Г.Гэрэлмаа: А.Ундраа гишүүний асуултад хариулъя.

Монгол Улс нь цөмийн байгууламжгүй хэдий ч цөмийн түлшний циклийг бүхэлд нь хэрэгжүүлдэг цөмийн зэвсэгтэй хоёр их гүрний дунд оршиж байдаг газар зүйн онцлогтой.

Монгол Улстай хиллэдэг Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын цөмийн байгууламжийн аюулгүй байдал нь тухайн улсын хяналтын байгууллага Олон улсын атомын энергийн агентлагийн хяналт доор байдаг.

Гэсэн хэдий ч болзошгүй ослын үед манай улсад хил дамнасан цацраг идэвхт бохирдол үүсэх эрсдэлтэй.

Мөн шинээр барьж буй болон үйл ажиллагаа явуулж буй цөмийн байгууламж, түүний ойр орчимд байх хөрш зэргэлдээ улсын нутаг дэвсгэрт нөлөөлж болзошгүй учир тухайн талтай зөвлөлдөх, хүсэлт гаргасан тохиолдолд

цөмийн байгууламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авах замаар өөрийн нутаг дэвсгэр дээр үүсэж болох гаднын нөлөөллийг тооцох, аюулгүй ажиллагааны үнэлгээ хийх, хил дамнасан ослын үед авах арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулах, хариу арга хэмжээ авах боломж энэ конвенцод нэгдэн орсноор үүсэх юм.

Ингэснээр өөрийн орны хүн ам, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, аюулгүй байдлыг хангах боломж бүрдэнэ.

Х.Булгантуяа: Гадаад харилцааны яамнаас Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа.

Ж.Соёлмаа: Сайн байцаана уу? А.Ундраа гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай 60 дугаар тогтоолоор өнөөдөр яригдаж байгаа энэхүү конвенцод Монгол Улс нэгдэж орох шаардлагатай гэсэн ийм шийдвэрийг гаргасан.

Тэр дагуу судалгаа, суурь судалгаанууд хийгдээд энэ конвенцод нэгдэж орох ажлууд хийгдэж байгаа.

Гадаад харилцааны яамны хувьд гэх юм бол нэгдүгээрт энэ цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулах хүрээнд нэгдэж орох конвенцуудын листийг гаргаад энэхүү конвенцуудыг нэгдэж орох судалгааг тухайн салбарын яамтай нь хамтарч хэрэгжүүлж байгаа.

Хоёрдугаарт, өнөөдрийн байдлаар цөмийн салбарт 10 гаруй конвенцод Монгол Улс нэгдэж орсон байна. Цаашид өнөөдөр яригдаж байгаа 3 конвенцод нэгдэж орсноор манайх олон улсын атомын энергийн агентлагийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаа, цөмийн зэвсэггүй статусаа давхар баталгаажуулж байгаа үүрэг юм.

Мөн Засгийн газрын.../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмэлт 1 минут өгье.

Ж.Соёлмаа: Мөн Засгийн газрын 2017 оны тогтоолоор олон улсын гэрээ болон гэрээний үүргийн хэрэгжилтийн тайлан гаргах байгууллагуудыг тодорхойлсон тогтоол байдаг.

Өнөөдрийн нэгдэж орсон гэрээ, конвенцын дагуу тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулаад мөн энэхүү конвенцын дагуу тайлангаа гаргах асуудлыг илүү үүрэгжүүлнэ. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлж дууслаа.
/алх цохив/

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 10.12-ын дагуу санал хураалтыг маргааш явуулна.

Ингээд дараагийн асуудалдаа оръё.

**Дөрөв.Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын
2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн,
соёрхон батлах/**

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн байгаа.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан танилцуулна.

Индэрт урья.

Ц.Туваан: Улсын Их Хурлын дэд дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 6 сарын 19-ний өдрийн Монгол Улсын цөмийн засгаас ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай 60 дугаар тогтоолоор Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор уг конвенцын нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орох асуудлыг Засгийн газрын 2023 оны 8 сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон.

Мөн түүнчлэн Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 11 сарын 21-ний өдрийн хуралдаанаар уг конвенцын нэмэлт, өөрчлөлтийг дэмжсэн болно.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл

баримтлалыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар 2024 оны 10 сарын 13-ны өдөр баталсан байна.

Засгийн газрын 2024 оны 11 сарын 13-ны өдрийн хуралдаанаар Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд 2024 оны 11 сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Монгол Улсад эрүүл мэнд, аж үйлдвэр, геологи уурхай, хөдөө аж ахуй, судалгаа шинжилгээ, хяналтын салбарт цөмийн технологийг анх 1934 оноос хэрэглэж ирсэн бөгөөд одоогоор 669 аж ахуйн нэгж, байгууллагад 2327 цацрагийн үүсгүүр ашиглаж байна.

Цацрагийн үүсгүүрийн хэрэглээ 1996 онтой харьцуулахад 5.8 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенц нь зөвхөн олон улсын тээвэрлэлтийн үеийн биечлэн хамгаалах арга хэмжээнд хамаарч байсан бол 2005 оны нэмэлт, өөрчлөлт нь цөмийн байгууламж, түүнчлэн дотоодын хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлтэд байгаа цөмийн материалын аюулгүй байдлыг хангах асуудлыг хамаарч байна.

Мөн конвенцод хамаарах гэмт хэрэгт цөмийн материалыг хууль бусаар нэвтрүүлэх, цөмийн байгууламжид хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулах зэрэг асуудлууд нэмэгдэж хорлон сүйтгэх ажиллагааны талаарх мэдээлэл солилцох, туслалцаа үзүүлэх, өргөтгөсөн хамтын ажиллагааны зохицуулалтууд нэмэгдсэн байна.

Конвенцын нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсон улс орон бүр цөмийн материалыг хулгайлах, хууль бусаар эзэмших, эдгээрт учирч болох бодит аюул бий болсон тохиолдолд олон улсын атомын энергийн агентлагт нэн даруй мэдэгдэх шаардлагатай.

Энэхүү мэдээллийг үндэслэн тухайн улсын өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах, цөмийн террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, бодит аюул тулгарсан тохиолдолд бусад орон холбогдох олон улсын байгууллагуудаас дэмжлэг авах боломжтой.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсноор цөмийн материал болон цөмийн байгууламжийн биет хамгаалалтыг олон улсын түвшинд хүргэх, цөмийн терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх эдгээр зорилтуудад нийцсэн үндэсний эрх зүйн орчныг бий болгоход дэмжлэг болно.

Конвенцын нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсноор Монгол Улс санхүүгийн ямар нэг үүрэг хүлээхгүй.

Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомжтой зөрчилдсөн зүйл, заалт байхгүй болно.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцод 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 164 улс нэгдэн орж, 44 улс гарын үсэг зурсан.

Тус конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт нь 2016 оны 5 сарын 08-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын байдлаар 137 улс нэгдэн орсон байна.

Иймд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хажекберийн Жангабыл танилцуулна.

Х.Жангабыл гишүүнийг индэрт урьж байна.

Х.Жангабыл: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Г.Тэмүүлэн нар Монгол Улс хэчнээн гэрээ конвенцод нэгдэн орсон болон ямар үүрэг хүлээдэг, хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд ямар сөрөг үр даалгавар үүсэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх шаардлагатай талаар тус тус үг хэлсэн болно.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжин, соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүд түрүүний нэгэн адил байгаа.

Ингээд танилцуулгатай холбоотой асуулт, саналтай гишүүдийн нэрийг авъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасалъя.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Конвенцыг соёрхон батална гэдэг бол Монгол Улсын хариуцлагатай, итгэл хүлээхүйц, дээрээс нь олон улсын түвшинд үнэлэгдэхэд чухал ач холбогдолтой гэж харж байгаа.

Нөгөө талдаа Монгол Улс үүрэг хариуцлагаа ухамсарлаж хүлээх нэг чухал асуудал хөндөгдөнө.

Өөрөөр хэлбэл олон улсын конвенцод нэгдэн орох, тухайн конвенцын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхээс гадна дотоодын аюулгүй байдалтай холбоотой асуудлыг сайжруулах үүргийг давхар хүлээж байгаа.

Цөмийн материалын аюулгүй байдалтай холбоотой асуудлууд байна. Ялангуяа энэ нэмэлт, өөрчлөлт соёрхон баталж байгаатай холбогдуулаад цөмийн материалын хууль бус ашиглалт, хулгай, террорист үйл ажиллагаанаас яг хэрхэн урьдчилан сэргийлэх юм бэ? Монгол Улс. Үүнийг асуумаар байна.

Цөмийн материалын тээвэр, хадгалалт, хамгаалалтад шинээр шаардлагууд тавигдаж эхлэх үү гэдгийг асуумаар байна.

Мэдээж конвенцын шаардлагыг биелүүлэхэд учирч болзошгүй санхүүгийн болон техникийн хүндрэлүүд гарахыг үгүйсгэхгүй.

Энэ дээр ямар урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Бид гадаад болон дотоод аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийн асуудлыг бид зайлшгүй бодох ёстой. Энэ дээр ямар санал, дүгнэлтүүд урьдчилсан байдлаар гарсан бэ гэдгийг асуумаар байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс Ц.Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Ж.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Энэ конвенцууд бид ингээд нэгдэж байгаа. Монгол Улс нийтдээ 10 гаруй конвенцод нэгдэх юм.

Тэгэхээр конвенц болгон бас маш нарийн зохицуулалтуудыг хангаж өгч байгаа. Энэ хоёр дахь энэ Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц 1980 онд батлагдсан. 2005 онд нэмэлт, өөрчлөлт хийсэн.

Тэгээд манайх энэ конвенцод элсэх шийдвэр гарчихсан. Тэгээд өнөөдөр Их Хурлаар орж ирж байгаа.

Тэгэхээр энэ конвенцод бид нэгдэн орсноор Олон улсын цөмийн энергийн агентлагийн мөрддөг энэ дүрэм журам дотор, энэ конвенц дотор нь бас орж үйл ажиллагаагаа хамтатган хэрэгжүүлэх ийм боломж нэгдэж байгаа.

Дээрээс нь терроризмтой, цөмийн терроризмтой. Ялангуяа энэ цөмийн материалын аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтаас ямар нэгэн байдлаар алдахад энэ конвенцод орсноороо нэн даруй Олон улсын атомын энергийн агентлагт мэдээлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ийм үүрэг хүлээж байгаа. Асуудлаа шийдүүлж авна.

Дээрээс нь энэ цөмийн материалтай холбоотой янз бүрийн гэмт хэрэг, ялангуяа хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулах нөхдүүд байвал эдгээрт олон улсын түвшинд хариуцлага тооцох ийм асуудлууд энэ конвенцод нэгдэн орсноор орж ирж байгаа.

Дээрээс нь ганц Монгол Улсын асуудал биш хөрш зэргэлдээ олон улсуудад ийм төрлийн гэмт хэрэг, цөмийн терроризмтой холбоотой асуудал үүсэхээс бас урьдчилан сэргийлж байгаа ийм асуудлууд байгаа.

Манайх элсэн орсноороо тодорхой үүргүүдийг хүлээнэ. Үүнийг гишүүн тодорхой хэлж байна. Энэ дээр бид цөмийн үүсгүүрүүдээ бодитойгоор биет хамгаалалтыг хийх ийм үүрэг хүлээнэ.

Дээрээс нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг мэдээлэхээс гадна энэ улсуудад хариуцлага тооцох ийм үүрэг хүлээж байгаа.

Энэ хүмүүсийг олон улсад энд тэнд нэвтрэх санкцад оруулах ийм үүрэг хүлээнэ.

Дээрээс нь Олон улсын атомын энергийн агентлагаас мөрдөж байгаа маш олон нарийн. Жишээлэх юм бол яг ийм гэмт хэрэг гарсан тохиолдолд хэн рүү холбогдох вэ, хаашаа яаж мэдээлэх вэ, эргэж ямар ар арга хэмжээ авах вэ гэх мэт асуудлуудаа бид тодорхой нарийвчилж өгч байгаа гэдгийг хэлье.

Гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөлөл дээр манай ажлын хэсэг Г.Гэрэлмаа нэмээд хариулчих.

Мэдээж энэ төрлийн олон улсын агентлагийн өмнө бид энэ конвенцод нэгдэн орсноор ямар нэгэн санхүүгийн хариуцлага хүлээхгүй ч гэсэн энэ конвенцын хэрэгжилтийг хангахад бид дотооддоо тодорхой зардлууд гараад явна. Энэ батлагдсан төсвийнхөө хүрээнд бид бүхэн хэрэгжүүлээд явж байгаа гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Байнгын хорооны саналаар Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, санал хэллээ.

Санал хураалтыг Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 10.12-ын дагуу санал хураалтыг маргааш явуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Тав.Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг
соёрхон батлах тухай хуулийн төсөл**
/Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн,
соёрхон батлах/

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Засгийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Тувааныг хууль санаачлагчийн илтгэлийг тавина.

Индэрт урьж байна.

Ц.Туваан: Улсын Их Хурлын дэд дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улс цөмийн энергийн салбарт 1972 оноос хойш Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээ, Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдсон баталгааг хэрэглэх тухай хэлэлцээр, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц, Цөмийн ослын талаар шуурхай мэдээлэх тухай конвенц, Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай конвенц зэрэг 10 орчим олон улсын гэрээ,

конвенцод нэгдэн орсон бөгөөд эдгээр олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлсээр ирсэн.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 6 сарын 19-ний өдрийн Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх тух статусыг шинэ түвшинд гаргах тухай 60 дугаар тогтоолоор Бага хэмжээний цөмийн материалыг шинэчилсэн протоколд нэгдэн орох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орсон улс орнууд Олон улсын атомын энергийн агентлагаас томилсон хяналт шалгалтын байцаагч нарын томилгоог хүлээн авах, шаардлагатай тохиолдолд хил нэвтрэх эрх олгох, эрхийг шинэчлэх зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, анхны тайланд тодорхойлсон байршил болон цөмийн материалын байршилд нэвтрэх эрхийг бүрэн олгох үүрэг хүлээнэ.

Мөн иж бүрэн баталгааны гэрээний дагуу тухайн улс орон Олон улсын атомын энергийн агентлаг болон түүний хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэж буй байцаагч нарт Олон улсын атомын энергийн агентлагийн халдашгүй дархан эрхийн тухай гэрээний холбогдох заалтуудад тусгасан давуу эрх, халдашгүй байдлыг хадгалах, хангах үүрэгтэй.

Монгол Улс нь цөмийн байгууламжгүй бөгөөд бага хэмжээний цөмийн материалтай улсын хувьд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орох нь өөрийн онцлог нөхцөл байдалд тохирсон цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх, улмаар цөмийн материалын ашиглалт, хэрэглээнд үр дүнтэй хяналт тавих, цөмийн аюулгүй байдлын баталгааг гүйцэтгэх, хянах техникийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, цөмийн материалтай хяналтын тооллогын улсын системийг бий болгох чиглэлээр Олон улсын атомын энергийн агентлагийн зөвлөх үйлчилгээг авах, дадлагажуулах хөтөлбөрт хамрагдах, цөмийн эрчим хүчний хөтөлбөр хэрэгжүүлэх баталгааг хангахад ойртох зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Шинэчилсэн протоколд нэгдэн орсноор Монгол Улс санхүүгийн ямар нэг үүрэг хүлээхгүй.

Монгол Улсад мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн зүйл, заалт байхгүй болно.

Олон улсын атомын энергийн агентлагаас 2024 оны 10 сарын 01-ний өдөр Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Цөмийн энергийн комиссын даргад ирүүлсэн албан бичигт олон улсын атомын энергийн агентлагийн захирлуудын зөвлөлийн шийдвэр 2005 онд гарснаас хойш багагүй хугацаа өнгөрсөн тул Монгол Улсын Засгийн газар зохих арга хэмжээ аваагүй тохиолдолд баталгааны дүгнэлтийг үргэлжлүүлэн гаргах боломжгүй болохыг мэдэгдсэн байна.

Энэ нь Монгол Улсын нэр хүнд олон улсад буурах, Олон улсын атомын энергийн агентлагаас Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр болон бусад дэмжлэг тусламжийг царцаах сөрөг үр дагавар үүсээд байгаа юм.

2024 оны 11 сарын байдлаар Олон улсын атомын энергийн агентлагийн иж бүрэн цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааны гэрээнд 191 орон, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд 63 улс протоколын шинэчилсэн хувилбарыг даган мөрдөж байна.

Иймд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай танилцуулна.

Н.Алтаншагай гишүүнийг индэрт урья.

Н.Алтаншагай: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд конвенцод нэгдсэнээр ямар ач холбогдолтой талаар, цаашид энэ төрлийн хэдэн конвенцод нэгдэх шаардлагатай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл цөмийн энергийн талаарх ойлголт, мэдээллийг олон нийтэд түгээх, мэдээллийг үнэн зөв, оновчтой хүргэхэд анхаарах, конвенцод нэгдсэний давуу болон сөрөг тал, эрсдэлийн талаарх ойлголтыг түгээх талаар асуулт асууж үг хэлсэн болно.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжин соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад

бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсэг түрүүний хоёр хэлэлцсэн асуудалтай адилхан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асууж, санал хэлэх гишүүдийн нэрийг авъя.

Д.Батлут гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ.

Б.Бат-Эрдэнэ: Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын 192 орноос 63 орон л энэхүү конвенцод нэгдсэн гэж ойлголоо.

Монгол Улс конвенцод нэгдэн орохдоо дараагийн үр дагавруудыг их сайн бодож тунгааж орж байх ёстой гэж ойлгож байгаа. Шинэчилсэн протоколыг хэрэгжүүлэх нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтуудад хэрхэн нийцэж байгаа вэ гэдгийг нэгдүгээрт би асуумаар байна.

Хоёрдугаарт, протоколын шинэчилсэн хувилбар өмнөхөөсөө юугаараа ялгаатай юм гэдгийг асуумаар байна.

Гуравдугаарт, энэ протоколыг баталснаар Монгол Улсын цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх бодлогод ямар хэмжээний хувь нэмрийг оруулах юм бэ гэдгийг асуумаар байна.

Сүүлийн асуулт нь Бага хэмжээний цөмийн материалтай холбоотой шинэ стандарт, арга хэмжээ байгаа юу гэдгийг асуумаар байна. Ийм 4 асуултад хариулт авахыг хүсэж байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ж.Бат-Эрдэнэ гишүүний асуултад Ц.Туваан сайд хариулах уу? Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколоор бид 63 улс одоогийн байдлаар элсчихээд явж байгаа.

Манайд нэлээн эрт энэ шийдвэр нь гараад манай улсад ирсэн. Бид хэлэлцэхгүй нэлээн удаасан.

Тэгээд ер нь энэ ондоо багтааж хэлэлцэхгүй бол бид Олон улсын атомын энергийн агентлагийн зүгээс тодорхой санкцад орох асуудал үүсээд байгаа.

Дээрээс нь олон улсын, ялангуяа Францтай ураны төсөл ашиглах олон улсын хэлэлцээр явж байгаа. Энэ конвенцод нэгдэхгүй бол бас сөрөг байх магадлалтай. Ийм албан бичиг хүртэл миний нэр дээр, сайдын нэр дээр ирсэн байгаа.

Тэгэхээр энэ конвенцод нэгдэн орж Та бүхнийг бас баталж өгөхийг хүсье.

Мэдээж энэ конвенцод нэгдэн орсноор Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтуудад ямар нэгэн харшлах зүйл байхгүй.

Бидний баталсан Тогтвортой хөгжлийн зорилт, Алсын хараа гэх мэт Монгол Улсын урт хугацааны бодлогын бичиг баримтуудтай энэ конвенц нийцэж байгаа гэдгийг бас хэлье.

Тэгээд манай ажлын хэсгээс түрүүний гишүүний сүүлийн асуулттай нийлүүлээд энэ баталснаар Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээнд хүлээсэн үүрэг дээр ямар нэгэн шинэ зүйл гээд сүүлийн хоёр асуулттай нь нэмээд хариулт өгчхөөрэй. Тодорхой хариулт.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүний дунд талын микрофон нь юм байна шүү.

Э.Нямдаваа: Ж.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа.

Монгол Улсад цөмийн байгууламж одоогоор байхгүй байгаа. Харин цацрагт ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйл ажиллагаа эхлэх шатдаа ороод явж байна.

Мөн эмнэлэг, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, судалгаа шинжилгээний байгууллагад цацрагийн үүсгүүрийг олон тоогоор ашигладаг.

Тэгэхээр бид эдгээр цацраг идэвхт үүсгүүрийнхээ аюулгүй байдлыг дотооддоо хангах ёстой.

Мөн Монгол Улсын хилийн ойролцоо хөрш орнуудын цөмийн түлшний циклийн байгууламжууд, хаягдлын ийм менежментийн байгууламжууд оршин байдаг.

Мөн Монгол Улсын хилээр цацрагийн бохирдолтой эд зүйл орж ирэх тохиолдлууд үе үе тохиолдож байсан.

Тэгэхээр Монгол Улсын хил дээр цацрагийн үүсгүүрийг илрүүлэх, бүртгэх, хянах энэ төхөөрөмжийг суурилуулан хяналт тавьж ажилладаг. /минут дуусав/

Х.Булгантуяа: Хариулт болохоор байна уу? Ж.Бат-Эрдэнэ гишүүн.

Нэмж минут өгье.

Э.Нямдаваа: Монгол Улсын дотоодод ашиглаж буй цацрагийн үүсгүүрүүдийг цацраг идэвхт хэмжээнээс нь хамааруулаад 5 ангилдаг.

1, 2 дугаар ангиллын хамгийн өндөр идэвхтэй үүсгүүрийг 2 давхар биет хамгаалалттай хийх шаардлагатай байдаг.

Энд Цөмийн энергийн комиссын ажлын алба, Хавдар судлалын үндэсний төв, Монгол Улсын Их Сургуулийн Цөмийн физикийн судалгааны төв хамрагдаж энэ биет хамгаалалтаа хийж ажилладаг.

Цаашид улсын онц чухал объект болгож энэ хамгаалалтыг сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа.

1-ээс 3 дугаар ангиллын үүсвэрүүдийн хувьд нэг давхар биет хамгаалалт байх ёстой гэсэн шаардлагууд тавигддаг.

Бага хэмжээний цөмийн материал шинэчилсэн протоколд нэгдэн орсноор Монгол Улс 30 хоногийн дотор өөрийн эзэмшилд байгаа бага хэмжээний цөмийн материалынхаа тайлан гаргаж гаргаж гаргаж өгөх ёстой.

Мөн Олон улсын атомын энергийн агентлагаас тогтмол хяналт шалгалт хийгдэнэ. Мөн шаардлагатай тохиолдолд тусгай хяналт хийгдэх зохицуулалттай байгаа.

Монгол Улсын хувьд цөмийн материалыг бүртгэх хянах энэ журмыг Засгийн газар 2020 онд батлан гаргасан. Хүчин төгөлдөр мөрдөгдөөд явж байгаа. Шинэчлэн батлах стандарт байхгүй байгаа.

Х.Булгантуяа: Б.Бат-Эрдэнэ гишүүн нэмж тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Монгол Улс Тогтвортой Хөгжлийн Зорилт 15 дээр эх газрын экосистемийг хамгаалахтай холбоотой асуудал тусгагдсан байдаг.

Саяын хариултуудыг ингээд харахаар тэр байхгүй, энэ байхгүй, энэ нь болоогүй байна, стандартгүй байна гэдэг олон асуудлууд хөндөгдөж байна л даа.

Тэгээд энэ протоколын хэрэгжилт дээр цөмийн материалын тээвэр хадгалалтын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байгаа тохиолдолд эко системд сөрөг үр дагавар үүсэж болзошгүй ээ гэж үзэж байгаа юм.

Тэгээд энэ дээр та бүхэн яг Тогтвортой хөгжлийн зорилт гэдэг агуулгаар нь яг товч тодорхой хариулт өгөөч ээ гэж хүсэж байна.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн микрофоныг өгье.

Э.Нямдаваа: Эдгээр конвенц, нэмэлт, өөрчлөлт, протоколууд нь цөмийн эрчим хүчний станц, мөн ураныг олборлох, боловсруулах үйл ажиллагаа, цацрагийн үүсгүүрийн хэрэглээ аль алинд нь үйлчилнэ.

Тэгэхээр цөмийн эрчим хүчний станц бол бас ногоон эрчим хүчит орж ордог.

Тэгэхээр энэ ногоон эрчим хүч үйлдвэрлэх, тэгээд энэ станцынхаа аюулгүй ажиллагааг хангахад энэхүү конвенцууд маань маш чухал үүрэгтэй.

Харин аливаа нэг тээвэрлэлтийн үед Цөмийн энергийн тухай хуулийн дагуу зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагааг явуулах шаардлагатай байдаг. Энэ тээвэрлэлтийн зөвшөөрлийн үед Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч нар холбогдох материалыг судалж үзээд аль болох хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар шаардлага тавьж ажилладаг.

Ингээд цацрагийн хамгаалалт аюулгүй ажиллагааг бүрэн хангуулсны үндсэн дээр эдгээр үйл ажиллагаа явагддаг ийм зохицуулалттай.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдээс протокол дээр үлддэг учраас асуултад хариулахдаа албан тушаалаа заавал хэлээд яваад байгаарай.

Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар.

Н.Наранбаатар: Конвенцод нэгдэнэ гэдэг бол мэдээж ард нь хариуцлага байж таарна. Хариуцлага хүлээж таарна.

Тэгээд үүний ард нэгдсэнээрээ бид ямар үүрэг хариуцлага хүлээх юм бэ? Тухайлбал, одоо нөгөө ан амьтанг хамгаалах конвенцод нэгдсэнээрээ Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замд хориг хашаа тор татахгүйгээс болоод олон бод мал ялангуяа тэмээ их дайруулж байгаа л даа. Сүүлийн үед. Манай Өмнөговийн нутагт.

Тэгээд хориг хашаа тор татна гэхээр олон улсын конвенцод нэгдчихсэн учраас өнөө зэрлэг амьтдын нүүдлийг хаачихна гээд татуулахгүй байх жишээтэй. Ингээд маш олон айлуудаас гомдол санал ингээд гарч байдаг.

Мөн усны конвенцод нэгдчихээрээ өнөө гадагшаа гараад байгаа Орхон гол, Хэрлэнгээс говь руу ус татах том төслүүд хэрэгжинэ гэхээр зэрэг бас олон улсын конвенцод гадагшаагаа гарч байгаа усыг хамаагүй, голдиарлыг нь өөрчилж болохгүй барихгүй гээд л олон асуудлууд энэ конвенцод нэгдсэнээрээ гараад байдаг юм билээ.

Тэгээд цаашдаа бидний хийх гэж байгаа ажил, бүтээн байгуулалтууд, тэгээд л уламжлалт мал аж ахуй, малчдад сөргөөр нөлөөлдөг юмнууд амьдрал дээр харагдаж байгаа юм.

Тийм учраас энэ конвенцод нэгдсэнээрээ аливаа сөрөг зүйлүүд гарах уу, үгүй юу?

Хэрвээ конвенцыг хэрэгжүүлэхгүй бид ямар хариуцлага хүлээх юм бэ гэсэн ийм танин мэдэхүйн асуулт.

Х.Булгантуяа: Ц.Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Бид энэ Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдсэнээр мэдээж тодорхой үүргүүдийг хүлээнэ.

Тэгэхээр энэ ямар үүргүүд байна вэ гэхээр нөгөө цөмийн материалыг цөмийн зэвсэг болон бусад тэсрэх төхөөрөмжид ашиглахгүй байх гэдэг. Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээн дотор байдаг энэ үүргийг хүлээнэ.

Мөн энэ чиглэлдээ Олон улсын атомын энергийн агентлагтай нягт хамтарч ажиллах үүрэг хүлээнэ. Цөмийн материалын бүртгэл хяналтын тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх гэдэг үүргийг хүлээнэ.

Мөн олон улсын атомын энергийн агентлагтай бүх төрлийн цөмийн материалынхаа экспорт, импортын хөдөлгөөнийхөө тайланг жил бүр өгөх ийм үүргийг хүлээнэ.

Мөн 30 хоногийн дотор анхны тайлангаа олон улсын атомын энергийн агентлагт өгөх, олон улсын атомын энергийн агентлагийн экспертүүдийн хяналт шалгалт хийх боломжийг би бүрдүүлж өгөх.

Мөн улс орнуудад цөмийн байгууламж барих эрх олгосон болон барих шийдвэр гаргасан асуудлууд болгондоо Олон улсын атомын энерги агентлагт нэн даруй мэдээлэх гэсэн ийм үүргүүдийг бид хүлээдэг.

Дээрээс нь энэ конвенцод нэгдэн орсноороо, бас орохгүй бол ямар асуудал үүсэх вэ гэж гэж асууж байна.

Тэгэхээр бид энэ нэгдэж байгаа олон улсын конвенц, протоколууд маань ялангуяа энэ цөмийн энергитэй холбоотой, цөмийн зэвсэгтэй холбоотой энэ асуудал олон улсын түвшинд маш өндөр хяналт доор, маш нарийн зохицуулалт дор явдаг.

Тэгэхээр бид бүхэн ганцаараа Монгол Улс дэлхийд бид орно, орохгүй гэхээсээ илүү олон улсын энэ конвенцуудад нэгдэх ийм шаардлага үүсэж байгаа. Тухайлах юм бол бид энэ конвенцод нэгдэхгүй бол энэ олон улсын, ялангуяа ураны олборлолтын олон улсын энэ Оранотай хийх гэрээний асуудал дээр хүртэл бас тодорхой хэмжээний санкц, хориг авах ийм магадлалтай.

Тэгээд ер нь энэ ондоо нэлээн хугацаа удчихсан. Надад ирсэн бичгийн дагуу энэ ондоо багтааж батлах гэсэн ийм үүргийг хүлээж байгаа гэдгийг бас танд хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут.

Д.Батлут: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколын асуудлыг өнөөдөр хэлэлцэж байна.

Анх 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар энэ асуудал орж 2022 онд Цөмийн энергийн комиссын хурлаар орж ирсэн байсан ийм мэдээллүүд байгаа.

Тэгээд 8 жилийн дараа соёрхон батлагдахаар Улсын Их Хурал дээр орж ирж байна л даа. Улсын Их Хурлын хоёр удаагийн бүрэн эрхийн дараа гэсэн үг.

Яагаад орж ирэх болсон юм? Энэ шалтгааныг надад нэг тайлбарлаж хэлж өгөөч ээ. Цаг хугацааны хувьд ийм байсан юм уу, ямар учир шалтгаан байсан юм болоо гэдэг дээр нэг хариулт авъя.

Хоёрдугаарт нь, энэ протоколд нэгдэн орсноороо Олон улсын атомын энергийн агентлагт бид бүхэн бүхий л зүйлээ баталгаажуулсан хэлбэрээр тайлагнах болж байна л даа.

Тэгээд энэ дотор чинь Монгол Улсын эрх ашигт нийцсэн, дээрээс нь Монгол Улсын нууцлалтай холбоотой мэдээлэл сэлт багтах юм уу? Би магадгүй бас

Монгол Улс нууцлалын зэрэг орох материалууд ч энэ дотор байгаа. Байх ёстой л гэж харж байгаа.

Хэрвээ тийм бол бид энэ дээр ямар байдлаар асуудалд асуудлыг шийдэх юм бэ? Бид аль аль талдаа үүрэг, бас хариуцлага хүлээх ёстой.

Тэгээд үүрэг хариуцлагаа хэрхэн бид бүхэн тоймлож гаргах ёстой юм бэ гэдэг дээр энэ дээр хариулт авъя. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ц.Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Эхний асуултад би хариулъя.

Хоёр дахь асуултад манай ажлын хэсэг бэлдэж байгаад тодорхой хариулт өгөөрэй.

Энэ яг үнэн. Сая Атомын энергийн агентлагаас 2024 оны 10 сарын 01-нд надад албан бичиг ирсэн.

Тэгээд энэ албан бичигт бүр 2005 оноос хойш Олон улсын атомын энергийн агентлагийн захирлуудын шийдвэр гарснаас хойш манайх энэ асуудлыг нэгдэн орох асуудлаа ярихгүй л яваад байсан байгаа.

Дээрээс нь 2015 онд бас Монгол Улсын Их Хурлаас энэ 60 дугаар тогтоолыг батлаад, тэгээд энэ протоколд нэгдэн орох асуудлыг Засгийн газар луу даалгавар өгсөн боловч энэ асуудал бас ингээд яригдаагүй хугацаа удсан.

2023 онд Засгийн газрын хуралдаанаар ороод Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор 2023 оны 11 сард жилийн өмнө орж дэмжигдчихээд бас яг энэ чуулган руу ороогүй ийм л асуудлууд байгаа юм.

Тэгэхээр ер нь бол бид цөмийн энерги гээд атомын асуудал гээд ярихаар л бүгдээрээ нэг тийм айж бэргэсэн, эндээс тойрч зугтаасан ийм асуудлууд байсан.

Ер нь атомын бөмбөг, цөмийн энерги аюултай гэдэг нэг тийм мэдээлэлгүй, мэдлэггүй байдлаасаа болоод нэлээн тойроод үүнийг барьж авахаас халгаад байсан асуудлууд байгаа.

Тэгэхээр би түүнтэй холбоотой болов уу гэж бодож байгаа.

Дээрээс нь бид бүхэн ч гэсэн дахиад нэг конвенцын асуудал. Тэр нь нөгөө цөмийн хог хаягдалтай холбоотой асуудлыг бас нэлээн нарийн судалж байж оруулж ирье гээд бас орхичихсон.

Жишээлэх юм бол ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны гээд энэ 4 дэх конвенцыг бид нэмэлт материалуудыг судалж байгаад оруулж ирье гээд бас л болгоомжилж байгаа юм.

Тэгэхээр иймэрхүү зүйл байсан болов уу гэж бодож байгаа.

Тэгээд ер нь сая би хэлсэн. Хэрвээ энэ конвенцуудад удаан хугацаагаар элсэж орохгүй байх нь Олон улсын атомын энергийн агентлагийн өмнө хүлээсэн үүрэг, дээрээс нь тэнд бас тодорхой хэмжээний хардлага төрүүлж байгаа юм.

Ямар зөрчилдөөн байгаад энэ конвенцуудыг батлахгүй байна гэдэг.

Тэгэхээр сүүлд ирүүлсэн бичиг дээр энэ ондоо багтааж батлахгүй бол бид бүхэн бас тодорхой санкцуудад оруулна гэсэн ийм бичиг ирсэн.

Тэгэхээр Монгол Улсад өнөөдөр Цөмийн энергийн хуульдаа өөрчлөлт оруулаад энэ уран олборлох тал дээр Францтай хамтарсан хөрөнгө оруулалтын гэрээ яригдаж байгаа яг энэ мэдээлэл, асуудал ярьж байгаа энэ үед бас үүнийг дагаж оруулж ирж батлуулж байгаа гэдгийг Та бүхэндээ хэлье.

Тэгээд хоёр дахь асуулт дээр манай ажлын хэсэг.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн микрофоныг өгье.

Г.Намчинсүрэн: Гишүүний асуултад хариулъя.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Г.Намчинсүрэн.

Нууцлалтай холбоотой асуудлыг манай улс Төрийн нууцын тухай хуульд заасныхаа дагуу улсын онцгой объектын байршил болон хамгаалалтын системийг нууцлалд хамруулаад явдаг.

Тэгэхээр энэ конвенцтой холбоотойгоор энэ хуульд заасан эрх хэм хэмжээ хөндөгдөхгүй гэж ойлгож болно.

Мөн нөгөөтээгүүр цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн техник, эдийн засгийн үндэслэл ч юм уу, орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлд бас холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тухайн компанийн зөвшөөрөлтэйгөөр бусдад дэлгэхээс бусад тохиолдолд нууцад хамаараад явж байгаа.

Х.Булгантуяа: Д.Батлут гишүүн тодруулъя.

Д.Батлут: Бас урт настай удаан жаргалтай хэлэлцсэн байна шүү. Тийм ээ. 8 жилийн хугацаанд.

Яах вэ, ард иргэдэд зөв ойлголт өгөх гэж хичээсэн л юм шиг байна. Тэгэхдээ хичээсэн дүр зураг нь сая Цөмийн энергийн тухай хуулийг асуудал яригдаж байхад төдийлөн сайн байгаагүй шүү дээ. Иргэд таг л байгаа.

Бид нэг зүйлийг л онцгойлж анхаармаар байгаа юм. Улсын Их Хурал ч гэсэн өөрөө нээлттэй байх, ард иргэдээсээ тодорхой санал санаачилгыг авч байх, хуулийн хэрэгжилт, хууль санаачлах гээд олон зүйл дээр иргэдээс санал авч байх тэр процессыг цахимжуулаад л хийгээд байгаа.

Гэхдээ яг энэ өөрөө цахимжуулалт маань бодитойгоор хүндээ хүрч, хүн тэр хууль санаачлах, хуульд тодорхой санал тусгах процесст оролцож байна уу гэвэл бараг үгүй байна. Чамлалттай байгаа.

Тэгэхээр бид мэдээллийг яаж үнэн зөвөөр хүнд хүргэх вэ гэдэг асуудал бол маш чухал.../минут дуусав/

Х.Булгантуяа: Д.Батлут гишүүн санал хэллээ. Тийм ээ.

Тэгэхээр хариулт өгч байгаад дахиад тэр нь хангалттай биш байна гэхээр буцаж нэмж дэгийн тухай хуулиар.

Санал хураалтыг дэгийн тухай хуулийн 10.12-ын дагуу маргааш явуулъя.

Ингээд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаан 3 цаг 00 минут үргэлжилж, 13 цаг 09 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД